



Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл
2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 01-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 01-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БОЛОН ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООДЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-30

1.Монгол Улс, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025.08.26-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/	4-30
---	------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Төсвийн байнгын хороодын
10 дугаар сарын 01-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хамтарсан хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 58 гишүүнээс 30 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 10 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Пүрэвдаваа, Д.Үүрийнтуяа, Л.Энхнасан;
Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Ч.Анар, Т.Аубакир, Б.Жаргалан, С.Лүндэг, Б.Мөнхсоёл, П.Наранбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Х.Тэмүүжин, Б.Энхбаяр, Ж.Энхбаяр, Д.Энхтүвшин;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа, Л.Гантөмөр, З.Мэндсайхан, Р.Эрдэнэбүрэн.

Нэг.Монгол Улс, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2025.08.26-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, мөн яамны Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Хүрэлбаатар, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн газрын Өрийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Д.Ариунтуул, Өрийн удирдлагын газрын дарга Л.Гантогтох, Улсын гуравдугаар төв эмнэлгийн захирал Ц.Төмөр-Очир, мөн эмнэлгийн Зүрх судасны үндэсний төвийн дарга Х.Мөнгөн-Өлзий, мөн төвийн зөвлөх эмч Д.Мөнгөнчимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, зөвлөх М.Отгон, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо хариуцсан референт С.Төрмөнх нар байлцав.

Хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, хэлэлцээрийн төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Да.Цогтбаатар, Ч.Номин, Д.Цогтбаатар, Д.Батбаяр, Б.Заяабал, С.Эрдэнэболд нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Улсын гуравдугаар төв эмнэлгийн Зүрх судасны үндэсний төвийн дарга Х.Мөнгөн-Өлзий нар хариулж, тайлбар хийв.

Г.Тэмүүлэн: Монгол Улс, Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулах “Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 12
Бүгд: 37
67.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлэхээр тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 28 минут үргэлжилж, 58 гишүүнээс 39 гишүүн хүрэлцэн ирж, 67.2 хувийн ирцтэйгээр 17 цаг 38 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Х.ГАНХУЯГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 16 цаг 10 минут

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ өдрийн мэнд хүргэе.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо болоод Төсвийн байнгын хорооны хамтарсан хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна. Та бүхэнд ирцийг танилцуулъя? 51.8 хувьтай. Нийт 56 гишүүн оролцохоос 29 гишүүн хүрэлцэн байна. Энхтайвангийн Бат-Амгалан гишүүн, Далай Батбаяр гишүүн, Ринчендоржийн Батболд гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Жадамбын Батсуурь гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Жадамбын Баясгалан гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Дуламын Бум-Очир гишүүн, Жамбалын Ганбаатар гишүүн, Гомбын Ганбаатар гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн, Хассуурийн Ганхуяг гишүүн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Хажикбэрийн Жангабыл гишүүн, Батжаргалын Заяабал гишүүн, Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн, Чинбатын Номин гишүүн, Ганбатын Очирбат гишүүн, Пүрэвжавын Сайнзориг гишүүн, Буяагийн Тулга гишүүн, Банзрагчийн Түвшин гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Дамдины Цогтбаатар гишүүн, Даваагийн Цогтбаатар гишүүн, Баттогтохын Чойжилсүрэн гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд нарын гишүүд хүрэлцэн ирснээр 2 Байнгын хорооны хамтарсан хуралдаан эхлэхэд бэлэн болсон байна аа.

Ингээд 2 Байнгын хорооны хамтарсан хуралдаан буюу 2025 оны 10 сарын 1-ний өдрийн хамтарсан хуралдаан нээснийг мэдэгдье ээ. Хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Нэг асуудал байгаа.

Монгол Улс Европын сэргэн босголт хөгжлийн банк хооронд байгуулах Зүрх судасны үндэсний төв байгуулах төсөл буюу Зээлийн хэлэлцээрийн төслийг хэлэлцэхээр байгаад байгаа. Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Ингээд Зүрх судасны үндэсний төв байгуулах төслийн зээлийн хэлэлцээрийн төслийг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан сайд танилцуулна. Таныг микрофонд урьж байна. 6 номерын микрофоныг өгье.

Б.Жавхлан: Эрхэм Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, эрхэм Төсвийн байнгын хорооны дарга нар аа, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 дугаар зүйлд Зүрх судасны үндэсний төвийг төрөлжүүлэн байгуулна. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 3 дугаар зүйлд Зүрх судасны үндэсний төвийг барих гэж тус тус заасан. Үүний дагуу Засгийн газрын зүгээс Зүрх судасны үндэсний төв байгуулах төслийг ЕСБХБ-ны 34.9 сая ам.долларын зээл болон

Люксембургийн Их Гүнт улсаас олгох 22.5 сая еврогийн буцалтгүй тусламжийн хамтарсан санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөн холбогдох гэрээ хэлэлцээрийг байгуулахаар ажиллаж байна.

ЕСБХБ-тай байгуулах зээлийн хэлэлцээр нь олон улсын гэрээний тухай хуулийн дагуу Монгол Улсын Их Хурлаар заавал соёрхон батлагдах гэрээ бөгөөд тус зээл нь баталгаат овернайт санхүүжилтийн хүү буюу софер дээр нэмэх нь 1.6 хувийн нэмэгдэл хүүтэй 18 жилийн хугацаанд эргэн төлөгдөх үүнээс 4 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй байна аа. Тус төслийн хүрээнд 120 ортой тусгай зориулалтын зүрх судасны эмнэлгийн барилгыг шинээр барьж тоног төхөөрөмжөөр бүрэн ханган ашиглалтад оруулах бөгөөд төсөл хэрэгжсэнээр зүрх судасны төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний хүртээмжийг 2 дахин нэмэгдүүлж жил бүр өсөн нэмэгдэж байгаа зүрх судасны өвчлөл нас баралтын хэмжээг үлэмж бууруулах өндөр ач холбогдолтой гэж үзэж байна аа. Энэхүү зээлийн хэлэлцээрийг 2025 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж дэмжсэн бөгөөд Засгийн газрын хуралдааны тэмдэглэх гэрээний төсөл танилцуулах материалыг та бүхэнд хүргүүлсэн болно оо. Та бүхэн Зүрх судасны үндэсний төв байгуулах төслийн зээлийн хэлэлцээрийг хэлэлцэн дэмжиж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Танилцуулга мэдээлэл хийсэн Жавхлан сайдад баярлалаа. Хамтарсан Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя. Сангийн яамнаас Сангийн сайд Жавхлан, тус яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Тулга, тус яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын Газрын хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг, Санхүүгийн бодлогын газрын өрийн удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Ариунтуул гэсэн бүрэлдэхүүнтэйгээр Сангийн яамнаас оролцож байна.

ЭМЯ-аас эрүүл мэндийн сайд Чинбүрэн сайд хүрэлцэн ирсэн байна. Тус яамны ТНБД Очирбат дарга, Санхүү эдийн засгийн бодлогын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Хүрэлбаатар. Яамнаас ийм бүрэлдэхүүнтэй орж байгаа юм байна. Мөн манай төсөл хэрэгжих Улсын гуравдугаар төв эмнэлгээс манай удирдлагууд эмч нар хүрэлцэн ирсэн байна. Улсын гуравдугаар төв эмнэлгийн захирал Төмөр-Очир захирал хүрэлцэн ирсэн байна аа. Тус эмнэлгийн Зүрх судасны үндэсний төвийн дарга Мөнгөн-Өлзий. Тус эмнэлгийн Зүрх судасны үндэсний төвийн зөвлөх Мөнгөнчимэг гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр оролцож байна аа.

Зээлийн хэлэлцээрийн төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хорооноос танилцуулахаар байгаа. Тус танилцуулгыг Эдийн засгийн байнгын хорооны гишүүн Очирбат гишүүн танилцуулна аа. Таныг микрофонд урьж байна. Очирбат гишүүн.

Г.Очирбат: Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 8 дугаар сарын 26-ны өдөр Монгол Улс ЕСБХБ хооронд байгуулах Зүрх судасны үндэсний төв байгуулах төслийн зээлийн хэлэлцээрийн төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой

зөвшилцөхөөр ирүүлсэн билээ. Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаараа дээрх хэлэлцээрийн төслийг зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Хэлэлцээрийн төсөл Зүрх судасны үндэсний төв байгууллагыг ЕСБХБ-ны 34.9 сая ам.долларын зээл болон Люксембургийн Их Гүнт улсаас олгох 22.5 сая евро буюу 26.4 сая ам.долларын буцалтгүй тусламжийг хамтарсан санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. ЕСБХБ-тай байгуулах зээлийн хэлэлцээр нь олон улсын гэрээний тухай хуулийн дагуу заавал соёрхон батлах олон улсын гэрээ бөгөөд тус зээл нь баталгаат овер найт санхүүжилтийн хүү, 1.6 хувийн нэмэгдэл хүүтэй 18 жилийн хугацаанд эргэн төлөгдөх үүнээс 4 жил нь үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй байна аа. Зүрх судасны үндэсний төв байгуулах төслийн хүрээнд 120 ортой тусгай зориулалтын зүрх судасны эмнэлгийн барилгыг шинээр барьж тоног төхөөрөмжөөр бүрэн ханган ашиглалтад оруулах бөгөөд төсөл хэрэгжсэнээр зүрх судасны төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг 2 дахин нэмэгд дүүлж жил бүр өсөн нэмэгдэж байгаа зүрх судасны өвчлөл нас баралтын хэмжээг бууруулах өндөр ач холбогдолтой гэж тооцоолжээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцээрийн төслийг хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд Монголын талаас санхүүжилт байгаа эсэх талаар, мөн барилга байгууламж болон тоног төхөөрөмжид тус бүр хэдэн сая евро зарцуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн Эмч нарын хүний нөөцийг дэмжихэд зээл тусламжийн хэдэн хувь нь зарцуулагдах, түргэн тусламжийн нисдэг тэрэгний үйлчилгээг орон нутагт нэвтрүүлэх эсэх талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Тулга Зүрх судасны үндэсний төв нь Улсын гуравдугаар төв эмнэлгийн өргөтгөл эсвэл бие даасан эмнэлгийн статустай байх эсэх талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа тухай бүр зээлийн хүүгийн хэмжээг тогтоосон банкны шийдвэрийг зээлдэгч заавал биелүүлэхээр заасан талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга Сангийн яамны зээлийн тооцооллыг зөв тооцсон эсэх талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат өнөөдрийн байдлаар баталгаат овер найт санхүүжилтийн хувьсах хүү хэд байгаа талаар, төсөл хэдий хугацаанд судлагдаад хэрэгжүүлэгч ямар нэгж байгууллагуудаар явсан талаар, мөн цаашид энэ төслийг дотоодын барилгын компаниудаар гүйцэтгүүлэх эсэх талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал ЭМЯ Зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх ямар бодлого барьж байгаа талаар, мөн эрүүл мэндийн салбарыг либералчлах буюу хувийн эмнэлгүүдийг хэрхэн нэвтрүүлэх талаар асуулт асууж, хариулт авсан болно оо.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцээрийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа, Г.Очирбат нар зээлтэй холбоотой санхүүгийн тооцооллыг дахин нэгтгэж ирүүлэх талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж, П.Батчимэг нар Зүрх судасны үндэсний төвийн барилгыг өөр байршилд барих талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн түргэн тусламжийн нисдэг тэрэгний үйлчилгээг нэвтрүүлэх талаар тус тус санал хэлсэн болно оо.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Монгол Улс ЕСБХБ хооронд байгуулах Зүрх судасны үндэсний төв байгуулах төслийн зээлийн хэлэлцээрийн төслийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулсан Очирбат гишүүнд баярлалаа.

Ингээд энэхүү зээлийн хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Тусдаа байгаа. Заяабал гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүн асуулт асууна.

П.Сайнзориг: Яах вэ зүгээр эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулалт хэрэгтэй байгаа гэдгийг бид ойлгож байгаа. Тэгэхдээ зүгээр энэ 120 ортой эмнэлэг байгаад байгаа юм. Энийг 34.9 сая доллар буюу би зүгээр ерөнхий багцаагаар нь ярьж байна.

125 тэрбум юм уу, 226 тэрбум төгрөгт барьж байгаа нь ер нь хэр үндэслэлтэй, бодитой ийм тооцоо судалгаа гарсан юм бэ? Би бол жоохон эргэлзэж л байна. 120 ортой эмнэлгийг 120 хэдэн тэрбумаар барина гэдэг чинь 126 тэрбумаар барина гэдэг чинь энэ зөв юм болов уу?

Хоёрдугаарт энэ төсөл 5 жилийн хугацаанд хэрэгжинэ гэж байна. Сангийн яам л хариулах болов уу даа. Энэ нөгөө гадаадын зээл тусламжийг зарцуулалт чинь ерөөсөө төсвийнхөө нөгөө тогтвортой байдлын зарчим тусгай шаардлага дээрээ очоод тулчхаад байгаа шүү дээ. Ер нь хэрэгжих юм болов уу. Тэгээд ингэж явж байтал нөгөө бараа материалын үнийн өсөлт инфляц байдаг юм уу бүх юмнаасаа болоод л ингээд хэрэгжих боломж нь хэр байдаг юм бэ? Би мэдээж ойлгож байгаа тусгай зориулалтын барилга байх. Тэгэхдээ энэ тооцоо судалгаа нэг л тийм одоо зөв л хийгдсэн байгаасай даа л гэж найдаж байгаа юм. Тэгээд мөнгө нь ороод ирдэг нөгөө тусгай шаардлагатай баригдаад зарцуулж болдоггүй нь ингээд л төслүүд маш удаашралтай яваад байдаг. Түрүүчээсээ 12 их наядын зээл тусламж чинь ингээд хэрэгжихгүй байж байгаа шүү дээ. Тэгээд л аваад л байдаг. Энэ зарчим дээрээ ер нь зүгээр цаашдаа яаж гарах юм бэ? Эхнийхийгээ хэрэгжүүлж чадаагүй байж байтал дараагийнхыг нь аваад ингээд асуудлыг ярьж гээд байгаа нь хэр зөв юм бэ?

Өмнөхүүд чинь ямар ч үр ашиггүй болоод байна шүү дээ, явахгүй байна. Тэгээд энийг авдаг дахиад л нэг ийм бичилт нь хийгдээд л байж байдаг. Жил жилд нэг жижгээр юу гэдэг юм бэ дээ? Бага багаар зарцуулалтыг нь тавьж өгдөг төслүүд нь олигтой явдаггүй. Тэгээд олон нийтэд болохоор баахан хүлээлт үүсгэчихсэн байж байдаг ийм зүйл болчих вий зүгээр ийм болгоомжлол байх юм. Тэгээд 120 ортой эмнэлгийг 126 тэрбум төгрөгөөр барих энэ зөв үү?

Г.Тэмүүлэн: Сайнзориг гишүүний асуусан асуултад хариулъя. Сангийн сайд Жавхлан 6 номер.

Б.Жавхлан: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. 90 оноос хойш 35 жилийн түүхэнд эрүүл мэндийн салбарт хэрэгжих гэж байгаа хамгийн үр дүнтэй хэлэлцээр гэх үү дээ. Хамгийн том төсөл болж орж ирж байгаа. Энэ төсөл маань 34.9 сая ам.долларын зээл, 22.5 сая ам.долларын буцалтгүй тусламжтай. Нийтдээ 57 сая еврогийн төсөл. Үүний 40 хувь нь буцалтгүй тусламжаар ийм хамгийн тохиромжтой холимог ийм санхүүжилтээр орж ирж байгаа ийм төсөл.

Люксембургийн их гүрэнт улсаас үзүүлж байгаа энэ нийтдээ энэ чинь одоо 8 дахь удаагийн буцалтгүй тусламж юм байгаа юм. Үүний сүүлийн 5 нь яг энэ 3 дугаар эмнэлэг дээр зүрх судасны энэ чиглэлээр эмч эмнэлгийн ажилтнуудыг бэлтгэх тоног төхөөрөмжөөр хангах ийм буцалтгүй тусламжаар нийтдээ бараг 40 гаруй сая еврогийн төсөл хэрэгжсэн байгаа өнөөдрийн хэмжээнд. Нэмээд энэ 22.5 саяын еврогийн ийм буцалтгүй тусламж энэ төсөл дээр нэмж орж ирж байгаагаараа энэ төслийн хамгийн том онцлог нь юм байгаа юм. Хэлэлцээр сайн хийгдсэн гэхдээ хамгийн том суурь нь энэ яам, захиалагч яам, хамгийн гол нь энэ 3 дугаар эмнэлгийн хамт олон өөрсдөө энэ Люксембургийн Вант улсдаа энэ өмнөх төслүүдээ маш амжилттай хэрэгжүүлсэн учраас өөрөөр хэлбэл цаад улсууд нь дахиад итгэл төрж байгаа учраас энэ улсуудад нэг дахиад ийм буцалтгүй тусламж үзүүлчихвэл энэ төсөл нь бүрэн ингээд дуусах юм байна гээд ингээд тал талаасаа одоо үнэхээр энэ зээлийг хэрэгжүүлэхгүй байхын аргагүй болтол л ирсэн ийм сайн төсөл байгаа юм аа. Тэр орны хэмжээг нарийн ширийн нь ЭМЯ-аас Захиалагчийн яамнаас ярих нь зөв байх. Энэ бодвол энэ их маш нарийн мэргэжлийн тэгээд мэс заслын өрөөнүүдэд нь шат шатын ийм тусгай зориулалтын ийм байгууламж байна гэж энэ ТЭЗҮ дээр нь маш ойлгомжтой ийм байгаа.

Тийм учраас 34 сая ам долларыг бид ер нь нэг энэ эмнэлэг маань өөрөө ь барилгын хугацаа нь 4-өөс 5 жилийн хугацаанд ингээд гүйцэтгэнэ. Бид нар нэг жил болгон 1.5-аас 1.8 их наядын зээлийн ашиглалт явуулж байхад энэ зээлийг жилдээ нэг 20-оос 30 тэрбумыг ингээд шингээгээд явахад бол төслийг хугацаанд нь амжилттай дуусгачихна гэсэн ийм төлөвлөлттэй харж байгаа.

Тийм учраас эрхэм 2 Байнгын хорооны эрхэм Улсын Их Хурлын гишүүд энэ төслийг бид нар ерөөсөө 100 хувь дэмжээд явах нь 4 жилийн Засгийн газрын мөрийн хөтөлбөрт ч орсон. 2025, 2026 оны жилийн төлөвлөгөөнүүдэд ч тус тус орсон. Мөн 2026 оны төсвийг өргөн барьсан энэ зорилтод салбарын хөрөнгө оруулалтуудад мөн томоохон байр суурь эзэлж байгаа ийм төсөл байгаа шүү гэдгийг хэлье ээ.

Г.Тэмүүлэн: Чинбүрэн сайд нэмж тайлбар өгөх байсан уу? Тэгье Чинбүрэн сайд 5 номер.

Ж.Чинбүрэн: 2 Байнгын хорооны эрхэм гишүүддээ бас нэмж хэлэхэд өнгөрсөн 10 жилийн хугацаанд гаднын хөрөнгө оруулалт зээл тусламжаар барьсан бүх эмнэлгүүдийн сайн муу туршлагаудыг хуримтлуулж ТЭЗҮ хийхэд нэлээн орсон. ТЭЗҮ-ийг хийсэн компани, Испанийн компани. Тэгээд Люксембургийн өөрийнх нь санхүүжилтээр энэ эмнэлгийг баривал ямар ямар төвөгтэй байдлууд үүсдэг юм бэ гэдгийг хүртэл сайн судалж, мэдэж, Монголын нөхцөл байдлуудыг үзээд. энэ баригдах барилга өөрөө 3 жил баригдана. Үйл ажиллагаа зүгшрүүлэх, чадавхжуулах, бэхжүүлэх ажиллагаа нь үндсэндээ 2 жил ингээд нийтдээ 5 жилийн хугацаанд төсөл үргэлжлээд ашиглалтад бүрэн нийцээд орох юм.

Тэгэхээр энэ бол бүүр ахисан түвшний зүрхний оношилгоо эмчилгээг хийх ийм чухал том төв болно. Нэг ёсондоо дэлхий нийтэд ийм том төвүүд тийм ч олон байдаггүй.

Тэгэхээр бид бас энэ эрүүл мэндийн салбартаа технологийн том дэвшил зүрх судасны чиглэлээр оруулж ирэх том ийм боломж бүрдэж байгаа ийм сайн өдөр. Өнөөдөр Ахмадын баярын өдөр. Өнөөдөр бид тооцоолол хийхэд 2050 он гэхэд Монгол иргэдийн 5 хүн тутмын нэг нь 60 наснаас дээш настай болно. Зүрх судасны

өвчлөл одоо хамгийн их өвчлөл ихтэй хөдөлмөрийн чадвар алдалт, нас баралтын гол тэргүүлэх шалтгаан болсон хэвээр байгаа.

Тэгэхээр энэ болгоныг шийдэх том сургалт шинжилгээ, ахисан түвшний эмчилгээ тэр битгий хэл бүр зүрх солих хэмжээнд хүртэл ажиллах ийм том эмнэлэг болж байгаа юм аа. Яг өртөг зардлыг нь аваад үзэх юм бол өмнө нь баригдсан нэгдсэн эмнэлгийн хэмжээнээс хүртэл өртөг нь бага болж байгаа. Яагаад гэхээр сая Сангийн сайдын хэлдгээр 24 сая доллар нь буцалтгүй тусламжаар орж ирж байгаа учраас энэ бас одоо өртөг нь багасаад энэ Монголд ийм том төв орж ирэх нөхцөл бүрдэж байгаад их баяртай байгаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Цогтбаатар гишүүн асуулт асууя.

Да.Цогтбаатар: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе ээ. Энэ 62 сая доллароор баригдах 34.8 сая ам.долларын зээлээр баригдах энэхүү эмнэлэг маань хугацаандаа орох байх гэж эндээс нэг юм бид нар дэмжиж өгөөд явуулах л байх л даа. Тэгэхдээ үнэ өртөг нь бас нэг хэсэг хугацааны дараа өсчих вий. Бид нар чинь нэг жилийн төсөв дээрээ нэг тоо тавьдаг, ирэх жил дахиад тэр нь нэмэгддэг. Тэрний дараа жил юу гэдэг юм бас нэг төгрөгийн үнэ ханш буурсан ч гэдэг юм уу татвар гаалийн үнэ өссөн ч гэдэг юм уу ингээд үнэ т өсөх эрсдэл гардаг. Энэ тал дээр ямархуу тооцоолол эрсдэлээ тооцож үзсэн байлгүй дээ л гэж бодож байна.

Тэгээд 2 дугаарт нь болохоор бид нар энэ дээр бас нэг тодорхой хэмжээний авлигын асуудал гарчих вий гэж би бас болгоомжилж байгаа юм. Уг нь би өнөөдрийн энэ хурал дээр нийслэлд энэ эрүүл мэндтэй холбоотой асуудал дээр зөвшөөрөл өгдөг НЭМГ-ын даргыг нийслэлд барилга барихад тодорхой хэмжээний зөвшөөрөл өгдөг нийслэлийн хэмжээнд барилга барих үргэлжлүүлэхэд зөвшөөрөл өгдөг тэр дарга нарыг ирж оролцооч гэж уг нь хүсэлт хүргүүлсэн ирээгүй байх шиг байна. Тэгээд санал нь бол одоо яг энэ 2 байгууллага дээр энэ чинь нэг талаасаа бид нар эмнэлэг барих гээд байгаа энэ чинь тэгэхдээ барилга учраас барилгатай холбоотой өгдөг зөвшөөрөл дээр нь бид нар Их Хурлаас яг ингээд зээлийг нь гаргаад өгдөг санхүүжилтийг нь шийдээд явуулдаг.

Тэгтэл барилгын барих зөвшөөрөл өгөгдөхгүй нийслэл дээр ингээд хувийн хэвшлийнхэн бол үгээ хэлчихсэн сууж байгаа. Барилга барих үргэлжлүүлэх, зөвшөөрөл өгөхгүй байна аа. Бид нар эскизээ батлуулчихсан, зургаа батлуулчихсан. Өөрийнхөө газар дээр барилгаа барих гэхээр нийслэл дээрээс онлайнаар зөвшөөрөл өгнө гэдэг өгөгддөггүй. Тэгэхээр иймэрхүү асуудлууд гараад цаг хугацаандаа бид нар энэ гоё хүчин чадалтай энэ гоё үнэтэй эмнэлгээ ашиглалтад авч чадахгүй. Тэгээд ингээд авч чадахгүй байж байх хугацаанд нь үнэ өртөг өсдөг иймэрхүү эрсдэл гарах вий дээ гэдэг дээр нь бас болгоомжилж асуулт асуух гээд байгаа юм.

Тэгээд гуравт болохоор энэ Эрүүл мэндийн сайдад уг нь 8 сард хэлсэн санагдаад байгаа юм. НЭМГ дээр шүдний эмнэлэг зөвшөөрөл авч чадахгүй онлайн гэдэг нэртэй, тэгээд одоо болтол хариу нь гардаггүй. Зөвшөөрөл нь өгөгддөггүй. Сургийг нь сонсохоор тэнд нэг ийм авлигын асуудал яригддаг. Бид нар онлайн болчихсон мөртөө тэр лог дээрээс бүх мэдээллүүдээ түүж аваад АТГ эсвэл тэр холбогдох газар нийслэлд зөвшөөрөл өгөөд байгаа газрууд нь өөрсдийгөө АТГ-т шалгуулчихмаар байгаа юм. Одоо бид нар нэг албан тушаалын энэ хэрүүл хийдэг биш ажил урагшилдаг тогтолцоог л иргэд бид нараас хүсээд байгаа юм. Бид нар энэ

дээр нэг дорвитой өөрчлөлт гаргаад энэ барилга барьдаг, эсвэл энэ эрүүл мэндийн зөвшөөрөл өгдөг нөхдүүд одоо энэ 2024, 2025 онд өөрсдийгөө өгөөд АТГ-т нэг шалгуулагдахмаар байна. Энэ дээр энэ төсөл хэрэгжүүлэх гэж байгаа салбарынхан ямархуу байр суурьтай байна? Энэ дээр хариулт өгөөч?

Г.Тэмүүлэн: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Сангийн сайд Болдын Жавхлан сайд хариулъя. 6 номер.

Б.Жавхлан: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя аа. Одоо Их Хурал дээр зээл соёрхон батлахын өмнө Сангийн яамнаас тавих бүх шаардлагуудаа бид шалгаад бүрэн болсон. Бүрэн нөхцөл хангасан учраас оруулж ирж байгаа. Тэгээд таны санаа зовж байгаа зүйлтэй би одоо санал нэг байна. Яг таны ярьж байгаа тэр эрсдэлүүд бий болсноос болоод нөгөө 6 сарын 1-нд төслүүд маань ажил болж чаддаггүйгээс хайран төсөв болдог. Эсвэл хэрэгжиж эхэлж байгаа нь дундуураа төсөвт өртөг нь нэмэгдээд сунжраад бүр ингээд дампуураад алга болдог. Тэгэхээр энийг одоо бид аль болох энэ эрсдэлийг бууруулах талаас олон талаас нь ингэж шахаж ажиллаж байна аа. Энэ төсөл дээр ингэж байгаа юм. Ер нь Монголын талын оролцоо их бага аа. Энэ Люксембургийн Их Гүнт улс ялангуяа манай дээр ингээд бараг 24 дэх жилдээ буцалтгүй тусламж өгөөд ажиллаж байгаа байхгүй юу. Тэгээд маш их туршлагатай болсон байна.

Энэ төсөл дээр Монголын талаас оролцоо маш бага. Энэ төслийн Монголын талын нэгж гэж байгуулагдах шаардлагагүй болсон. Яагаад вэ гэхээр Люксембургийнх нь талаас өөрсдөө санаа зовоод өөрсдөө менежментийн баг гаргая гэж байгаа юм. Тэрнийх нь 800 мянган долларын төлбөрийг EBRD-аас гаргая гэж байгаа юм. Одоо тэгэхээр Монголын талаас бид нар хийх ажлуудаа захиалагч яам болон захиалагч эмнэлгээс бидэнд тайлагнасан эндээ нийслэлээс бүх зөвшөөрлөө авчихжээ. Газраа авч байжээ, техникийн нөхцөлүүдийнхээ зөвшөөрлийг авч байж энэ хашаан дотроо юм байна. Нэмж авах шаардлага байхгүй. Зээл нь соёрхон батлагдаад менежментийнх нь баг нь гаднаасаа хүрээд ирнэ. Тэгээд тэр нөгөө тендер худалдан авах ажиллагаануудаа бүгдийг нь тэндээсээ зохион байгуулагдаад тэдний дүрмээр ингээд явах нь ээ.

Тийм учраас хэдүүлээ энийгээ нэг чангахан шиг атгаж аваад ингээд нэг гараанаас нь гаргаад тэгээд л ингээд хүлээгээд суух нь ээ.

Г.Тэмүүлэн: Нэмж хариулах юм уу? Чинбүрэн сайд. 5 номер. Чинбүрэн сайд нэмж тайлбар мэдээлэл өгье.

Ж.Чинбүрэн: Цогтбаатар гишүүн ээ энэ тусгай зөвшөөрлүүд бүгд авагдчихсан байгаа. 2022 онд нийслэлийн Хот байгуулалт барилгын хөгжлийн төвөөр баталгаажсан. Нийтдээ 15 төрлийн тусгай зөвшөөрөл бүгд хийгдсэн. Зураг төсөв хийгдчихсэн, ажлын зураг хийгдчихсэн, газрын сонголтоо хийчихсэн. Одоо ерөөсөө зээл та бүхэн соёл соёрхон баталж өгвөл барилгын ажил нөгөө сонгон шалгаруулалт зарлаад л тэгээд л барилгын ажил нь эхлэхэд бэлэн байгаа шүү.

Тэгэхээр бид тэр алдааг бол давтахгүй ээ сунжрахгүй ээ.

Дээрээс нь эрсдэлийн менежментийн зөвлөх баг хүртэл авчихсан.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Чинбатын Номин гишүүн асуулт асууя.

Ч.Номин: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Би юун түрүүнд энэ Зүрх судасны үндэсний төвийн байгуулах төсөл энэ дээр авч байгаа зээл буцалтгүй тусламж бол дээрээс нь энэ олон улсын прожект менежменттэй орж ирж байгаа. Энэ бол үнэхээр сайн орж ирж байгаа гэдгийг Жавхлан сайд, Чинбүрэн сайдад хэлье ээ. Энэ бол бенчмарк болохоор сайн төсөл болж орж ирж байгаа. Тэгээд энийг бид бүхэн хэрэгжүүлэх нь туйлын зөв тэгээд энийг зарчмын хувьд дэмжиж байгаа гэдгийг хэлье.

Тэгээд бас нөгөө талдаа би саяхан өөрийн ойрын хүний эрүүл мэндийн шалтгаанаас болж 3 дугаар эмнэлэг дээр очиж байсан. Тэгээд энд байгаа эмч эмнэлгийн ажилчид үнэхээр мэргэшсэн маш сайн хүмүүс байдаг юм байна гэдгийг өөрөө мэдэрсэн. Тэгээд бидний хувьд бол тоног төхөөрөмж цаашлаад эмнэлгийн байгууламжуудыг сайн болгож өгөх юм бол олон улсад гадагшаа явж энэ зүрх судасны чиглэлээр эрүүл мэндийн үйлчилгээ авч байгаа үйлчилгээг багасгах, нөгөө хэлээд байгаа валютын урсгалыг багасгах энэ нөхцөлийг би болгоно гэж харж байгаа учраас энэ маш зөв төсөл гэж харж байгаа. Тэгээд саяхан бас нэг судалгаа харж байсан. Тэгээд эндээс харахад бид нар чинь Монгол Улсын хэмжээнд энэ хавдрын нөхцөл байдлыг хүндэрч байна, хавдрын нөхцөл байдлаас шалтгаалж нас баралтын тоо өндөр байна гэж байгаа бол энэ зүрх судасны чиглэлээр нас барж байгаа хүмүүсийн тоо үүнээс даруй 20 гаруй хувь өндөр байгаа юм байна лээ.

Тэгэхээр бидний хувьд энэ маш яаралтай хийж хэрэгжүүлэх ёстой төсөл гэж харж байгаа. Тэгэхээр энийг дэмжиж байгаа. Ганц л асуулт байна. Энэ ямар асуулт байна вэ гэхээр энэ буцалтгүй тусламжаар энэ 26 сая долларын тоног төхөөрөмжийг авч байгаа юм байна. Энэ гэрээн дээр ингээд эргүүлээд харахаар энэ тоног төхөөрөмж нь бид нар мэдээж одоо ингээд гэрээ контрактаа хийгээд явах байх. Тодорхой түвшинд өөрчлөлт оруулах эсвэл орчин үеийн нөхцөл байдалтай уялдсан илүү шинэлэг тоног төхөөрөмжийг сонгох боломж байгаа юм болов уу гэдэг л асуулт байна.

Г.Тэмүүлэн: Номин гишүүний асуултад хариулъя. Чинбүрэн сайд 5 номер.

Ж.Чинбүрэн: Номин гишүүнд баярлалаа. Яг голыг нь олж хэлж байна. Ер нь бол Монгол хүний нас баралтын голлох шалтгаан бол ерөөсөө зүрх судас байгаад байгаа шүү дээ. Тэгээд энэ нь болохлоор хавдрыг бодох юм бол агшин зуурын яаралтай, цаг алдахгүй тусламж, үйлчилгээ үзүүлэхгүй л бол болохгүй. Тэгээд дэлхий дахинд хөгжилтэй оронд нас барах битгий хэл бүр хөдөлмөрийн чадвар алдахгүй болох хэмжээнд зүрхний шигдээсийг менежмент хийж чаддаг болчихсон байгаа. Бид одоо энэ 2024 оны тоо баримтыг аваад үзэх юм бол нийтдээ 18200 гаруй хүн нас барахад 3-ны 1-ийг нь аварч болох байсан гэж үзэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр өнөөдөр бидэнд энэ зүрх судасны төв ямар чухал вэ гэдэг нь энд харагдаж байгаа.

Тоног төхөөрөмж нийтдээ 24 орчим сая доллар. Энэ ганцхан тоног төхөөрөмж биш, тоног төхөөрөмжүүд тэдгээрийг суурьшуулах, ажиллагаанд оруулах, хэвшүүлэх, эмч ажилчдыг сургах. Гэхдээ энэ бүх төсөл түрүүн Сангийн сайдын хэлдгээр энэ 24 жилийн туршид хийгдэж, суурь нь тавигдаж, Монгол эмч нарыг өдий зэрэгтэй ийм мундаг болтол нь сургахад Люксембургийн 8 удаагийн буцалтгүй

тусламжийн үр дүн бий болсон. Энэ үр дүнд бид орон нутагтаа хүргэх гээд байгаа шүү дээ.

Өнөөдөр бид энэ зүрх судасны төв байгуулснаараа гадагшаа урсах урсгалыг багасгаж байгаа. Дараагийн та бүхэнд толилуулах ADB-ийн том төсөл түргэн тусламжийн зүрх харвалт шигдээсний төсөл бол орон нутагт нь суурьшуулах Улаанбаатар руу ирүүлдэггүй байх. Ингээд энэ төслүүд хоорондоо ерөөсөө уялдаатай нэг интеграцлагдсан ийм төслүүд явах юм. Энэ ахисан шатын гэж яриад байгаа нь аймгуудаа эмчлэх боломжгүй болоод нэмэлтээр төлөвлөгөөт байдлаар эмчлэх улсуудаа Улаанбаатартаа авчирдаг болно. Улаанбаатараасаа гадагшаа явдаггүй байх энэ нөхцөлийг бүрдүүлэх ийм тоног төхөөрөмж. Тэгэхээр тоног төхөөрөмжүүд дандаа шинэ, орчин цагийн. Өнөөдөр бид гар утсаа дандаа шинэ утас барьж чадаж байгаа бол эрүүл мэндийн салбарт технологийн хоцрогдоогүй хамгийн шилдэг тоног төхөөрөмжүүдийг суурилуулж ажиллуулах ийм тоног төхөөрөмжүүд тавигдана. Тухайлах юм бол судсан доторх эмчилгээнүүд, хагалгааны нээлттэй хагалгаа, судсан дотуурх эмчилгээ.

Дээрээс нь хэм алдалтуудыг түлдэг барьдаг эмчилгээний аргууд, мөн одоо технологи нэвтэрч байгаа оношилгооны тиймээ өнөөдөр бид зүрхийг маш олон төрлийн аргаар оношилж байна. CD, EMRI авхуулаад л зүрхний ангио хүртэл оруулаад л ингээд л бүгдийг нь хийх цогц том төв болно оо.

Г.Тэмүүлэн: Хариулт хангалттай гэж үзэх үү. Дамдины Цогтбаатар гишүүн асуулт асууна.

Д.Цогтбаатар: Би энэ төслийг дэмжиж байгаа. Яагаад гэвэл би бүр ёстой эхнээс нь энэ төслийг мэднэ. Шан Клод Юнкер Ерөнхий сайд байхаасаа энэ төслийг дэмжиж хэрэгжүүлж явж байсан. Жан Клод Юнкер гэдэг хүнийг бид нар талархалтайгаар санаж байх ёстой. Яагаад гэвэл үнэхээр Монгол Улсыг дэмжиж EBRT гэдэг энэ байгууллагад ороод EBRT-ийн өнөөдөр Монголд хийчихсэн байгаа нийт хөрөнгө оруулалтын багц нь 2 тэрбум доллар лав гарчихсан байж байгаа байх. Манай Монголын хамгийн том хөрөнгө оруулагчдын нэг. Тэгээд энэнд ороход тэр жижиг Люксембург улс Жан Клод Юнкер сайд бид нарыг дэмжиж яваад бидний мөнгө дүрмийн санд нь хүрэхгүй байхад тэр мөнгийг босгоод бидний өмнөөс өөр орноор төлүүлээд бид нар өнөөдөр Европын хөгжлийн банкны EBRT-ийн гишүүн болчихсон тэндээс зээл авдаг болчихсон хөнгөлөлттэй зээл аваад 2 тэрбум долларын хөрөнгө оруулалт хийчихсэн явж байгаа юм.

Тэгэхээр энэ бол үнэхээр хамгийн амжилттай явсан төслүүдийн нэг 2009 онд Жан Клод Юнкер Ерөнхий сайд Монголд ирэхдээ яг энэ төсөлтэй очоод би танилцаж байсан шиг санаж байна. Тэгээд энэ бол одоо ингээд үр дүнтэй явж байгаад би их баяртай байна аа. Тэгээд энийг бол дараагийн шатад нь EBRT-ээсээ зээлээ аваад гаргаад явах гэж байгаад баяртай байна. Ер нь Монгол Улс нөгөө эрүүл мэнд бүгдээрээ л ярихлаараа эрүүл мэндийн салбар боловсролд хөрөнгө оруулалт хийх ёстой, хүндээ хөрөнгө оруулалт хийх ёстой гээд. Хүнийхээ эрүүл мэндэд хөрөнгө оруулалт хийхгүйгээр өөр юунд хийх юм. Энэ тэгээд 120 ортой эмнэлгийг бол би дэмжиж байна. 126 гишүүнтэй парламенттай байснаас 120 ортой юу зүрх судасны төвтэй байх нь би хамаагүй дээр гэж үзэж байгаа.

Тэгээд 126 гишүүн дээр юу ч бодохгүй гараа өргөцгөөчхөөд 120 хүнтэй эмнэлэг дээр яах вэ, ийх вэ гээд яриад байгааг би сайн ойлгохгүй байгаа. Харин

одоо энэ дээр нэг юм би асуумаар байна. Наадах чинь бид нар энэ төвийн сургалт судалгааны томоохон төв болгож тийм амбицтайгаар ажиллаж чадах уу үгүй юу? Өөрөөр хэлбэл зөвхөн Монголын түвшний биш бүсдээ бид нар нэгэнт гаднын Европын тусламж дэмжлэг авч байгаа юм чинь тийм том амбицтайгаар тийм том төв байгуулж чадвал их сайн байгаа юм. Тийм амбиц тийм зорилго байгаа юу?

Манай эрүүл мэндийн салбарынхны мэдлэг бол сүүлийн үед үнэхээр ахиж байгаа. Тэр рүүгээ явахад энэ төсөл тус болж чадах уу л гэж асуумаар байгаа юм.

Г.Тэмүүлэн: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Чинбүрэн сайд 5 номер.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Энэ төслийг бас амь оруулахад энэ ажлын санхүүжилтийг манлайлж байгаа тэр эрхмүүдийг энд дурсаж хэлж байгаад их баяртай байна. Энэ төсөл өөрөө Европын сэргээн босголтын банк тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт 2 хоорондоо яг шүтэлцээтэй. Энэ байгуулагдсанаараа бид зөвхөн Улаанбаатар хот биш Монгол Улс биш бүсийн том төв болох бүрэн боломжтой болно. Тухайлах юм бол олон төвүүдэд хийж чаддаггүй эмчилгээг өнөөдөр манай Улсын гуравдугаар төв эмнэлгийн зүрх судасны эмч нарын баг хийж чадаж тэр битгий хэл зүгээр одоо Монголынхоо бусад эмнэлгийн эмч нарыг сургаад зогсохгүй гаднаас хүртэл хүмүүс ирж эмчлүүлж байгаа.

Тэгэхээр ер нь зүрх судасны энэ өвчлөлийг нээлттэй биш судсан дотуур нь хийдэг энэ технологи нь өөрөө нэлээн ур чадвар шаардсан өртөг зардал ихтэй технологийн том дэвшлүүдийг нэхдэг. Зөвхөн ангиографийн аппарат нь гэхэд зөвхөн 2 талаас нь хардаг биш 3 ди-ээр хардаг 3 панельтай байх жишээтэй. Дотуур нь хэрэглэж байгаа хэрэгслүүд нь өөрснөө бид хамгийн сайн технологийг авч хэрэглэж чадаж байна өнөөдөр. Өнөөдөр ЭМД-ын сангаас зөвхөн одоо энэ хамгийн төвөгтэй зүрхний энэ дотор стенк тавих зардал нь 100 саяд аваад явж байгаа шүү дээ. Энэ болгоныг бид дааж чадаж байгаа. Тэгэхээр энэ санхүүжилтийг бас шийдэж чадаж байгаа нь эмч нарт технологи хөгжүүлэх боломжийг олгодог бас нэг том хөшүүрэг байдаг. Энийг бас бид хийж чадаад одоо тоног төхөөрөмжөөр нь бүр цоо шинэ технологиуд тавиад өгөхлөөр би ямар ч байсан Буриадаас ирнэ л гэж найдаж байна. Ингээд цаашаа хөгжүүлээд манай эмч нар одоо дэлхийд олон олон сайхан илтгэлүүдээ тавиад ирвэл наашаа ирэх урсгал нэмэгдэнэ ээ. Энэ бол зүгээр нэг Монголд зориулсан төсөл биш. Энэ бол дэлхийд зориулсан төсөл. Дэлхийн хэмжээний төсөл өө гэж хэлье.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Батбаяр гишүүн асуулт асууя.

Д.Батбаяр: Ажлын хэсгийнхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Тэгэхээр улсын 3 дугаар эмнэлэг дээр тулгуурлаад яг энэ зүрх судасны мэргэшсэн төвлөрсөн ийм төв байгуулах гэж байгааг бол зарчмын хувьд нь дэмжиж байна. Тэгээд сая өөрөө ч ярьж байна. Чинбүрэн сайд ч ярьж байна шүү дээ. Энэ бол зөвхөн Монгол Улсын хэмжээнд ч биш яг бүсийн хэмжээнд энэ Сибир, Төв Азийн хэмжээнд үйлчилгээ үзүүлэх боломжтой ийм төсөл болно оо гээд. Ер нь бол төсөл маань өөрөө аливаа гадаадын зээл тусламжууд бол эргэн төлөгдөхдөө илүү амар илүү хөрөнгө оруулалт нь бол тодорхой буцаж өөрийгөө хөрөнгө оруулалт нь буцаж энэчээнээсээ нөхөгддөг байдлаар явагдвал илүү оновчтой болов уу гэж хараад байгаа юм.

Тэгээд энэ танилцуулгыг харж байсан. Би 2 асуулт асуумаар санагдаж байна.

Нэгдүгээрт нь эмнэлгийнх нь салбарын чиглэлээр тэгээд эдийн засгийн болон нийгмийн үр ашиг гэдэг дээр нь хангалттай бичээгүй байна. Жоохон тодруулаад асуучихъя гэж бодож байна. Яг энэ барилга байгууламж маань ашиглалтад орсноор нийтдээ ахиад ямар шинээр төрөлжсөн эмчилгээ бий болох вэ? Хэдэн ажлын байр бий болох вэ? Одоо 3 дугаар эмнэлэг дээр хийхгүй байгаа ямар шинэ эмчилгээ нэвтрэх вэ гэдэг нэг ийм асуулт байгаад байгаа юм.

Хоёрдугаарт нь болохоор санхүүгийн хувьд нь асуумаар байгаад байгаа юм. Ер нь бол манайд хэрэгжиж байгаа энэ гаднын зээл тусламжуудын нэлээн ихэнх хувийг нь энэ нөгөө буцаад гарахдаа техник арга зүйн зөвлөх үйлчилгээ гээд ингээд гараад явчихдаг. Тэгэхээр нөгөө яг жинхэнэ бодитой үлдэж байгаа хөрөнгө оруулалтынх нь хэмжээ нь багасаад явчихдаг ийм сул талтай. Гэхдээ энэ дээр бол арай гайгүй боломжийн маягаар хийгээд явуулчихсан юм юм байна л даа. Яг энэ нөгөө техник арга зүйн зөвлөх үйлчилгээ гэдэг нь 994 мянган доллар нь болохоор Европын сэргээн босголтын банканд яг тусад нь ялгаж өгөөд энэнээс илүү хэтрэхгүй. Үлдсэн нь бол цэвэр яг энэ барилга байгууламж болон тоног төхөөрөмжид нь зарцуулагдана гээд ингээд ороод ирчихсэн юм байна. Энэ би оновчтой болчихож гэж хараад байгаа юм. Асуух гээд байгаа зүйл маань болохоор энэ зураг төсөл маань өөрөө 2017 он, 2020 онд Люксембургийн компани гүйцэтгэсэн гэж байгаа байхгүй юу. Өнөөдөр чинь 2025 он. Тэгэхээр энэ магадлал энэ тэр яаж хийгдсэн бэ? Одоо энэ ахиад энд байгаа үнийн дүнгээсээ яг ингээд төсөл хэрэгжээд явахад хэдэн хувиар ямар нэгэн байдлаар өсөх, нэмэгдэх нөгөө зээл тусламж маань нэмэгдэх ийм эрсдэл байгаа юу гэсэн ийм 2 асуулт байна.

Г.Тэмүүлэн: Батбаяр гишүүний 2 асуултад хариулъя. Чинбүрэн сайд 5 номер асуултад хариулъя.

Ж.Чинбүрэн: Батбаяр гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр бид бас ард иргэдийнхээ амь насыг аврах, эрүүл амьдрах, хөдөлмөрийн чадвар алдалтгүй амьдарч чадах хугацааг хүртэл мөнгөөр дүгнэдэг болчихсон. Эрүүл мэндийн салбарын нэг эдийн засгийн том тооцоолол хийж чаддаг болсон зүйл нь энэ Дэйли гэж нэрлээд байгаа хөдөлмөрийн чадвар алдалтгүй амьдарсан жилүүдийн тооцоо гэдэг. Тэгэхээр би энийг танд нэг уншаад харуулаадахъя. Жилд дунджаар 627 эрүүл амьдралын алдагдсан жил аврагдана гэсэн үг 627. Энийг 84 нас баралтыг сэргийлэх гээд бодох юм бол үндсэндээ мөнгөн дүнгээр бодох юм бол 57 сая 59 мянга 684 долларыг хэмнэх боломжийг эрүүл мэндийн салбарт олгоно гэж байгаа.

Дээрээс нь энэ тоног төхөөрөмжийг нэмж барьснаараа бид 45 ажлын байр нэмэгдэнэ. Олон олон шинэ технологиуд орно. Тухайлах юм бол хабрид хагалгаа гэж байгаа юм. Нээлттэй судсан дотуурх хагалгаанууд. Жишээлбэл тэр хэм алдалтыг зохицуулдаг түлэх эмчилгээ гэхэд тэрийг шинэ аргачлалуудыг оруулах дээрээс нь нөгөө судсан дотуурх бүлэнг нь хайлуулах, авах, стенк тавих, мөн цүлхэн гэж ярьдаг. Тиймээ тархины судасны цүлхнүүдийг задрахаас нь сэргийлэх технологиуд. Одоо хийж байгаа технологиудаа дандаа ахисан түвшинд, оношилгоонууд ч гэсэн дандаа ахисан түвшинд. Нөгөө ахисан түвшин гэж яриад байгаа нь бид одоо ингээд эмнэлгүүдийг дэлхий даяар бол 5 түвшинд яг хувааж байгаа юм. Бүүр анхан шатных, дунд ингээд 5 гэдэг бол хамгийн дээд зэрэглэлийн эмнэлгийн тусламж үзүүлдэг эмнэлэг. Одоо зүрх солих нь байна шүү дээ. Зүрх

шилжүүлэн суулгана. Тэгэхээр энэ болгоныг хийж чаддаг эмнэлэг байна гэдэг маань өөрөө 5 дугаар зэрэглэлийн эмнэлэг. Хамгийн дээд түвшний эмнэлэг болно оо.

Магадлангийн тухайд бол 2017 онд хийгдээд 2022 онд апдэйт хийсэн шүү. 22 онд апдэйт хийгээд тэгээд энэ Барилга хөгжлийн төвөөрөө ахиж баталгаажуулагдаад хийчихсэн. Тоног төхөөрөмжийн хувьд түрүүн Номин гишүүн асууж байсан. Барилга 2029 онд баригдаад дуусаад тэгээд тоног төхөөрөмжийн жагсаалтыг шинэчилнэ. Тэгээд ямар ямар тоног төхөөрөмжүүд суурилуулах вэ гэдгээ 2029 онд авахаасаа өмнө шийднэ гэдгийг та бүхэн анхаараарай.

Г.Тэмүүлэн: Жавхлан сайд нэмж тайлбар өгье. 6 номер.

Б.Жавхлан: Батбаяр гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье өө. Энэ зээлийн чанар одоо нэлээн тийм өндөр өгөөжтэй зээл байгаа юм аа. Саяын таны хэлж байгаа тэр нөгөө 900 мянга байна шүү дээ. Барилгын хяналт зөвлөх үйлчилгээний 900 мянга чинь буцалтгүй тусламж юм байгаа юм. Буцалтгүй тусламж. Люксембургээс тэр зөвлөх баг нь ирнэ. Санхүүжилт нь Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас буцалтгүй тусламжаар орж ирнэ. Тэр 2 талаасаа буцалтгүй тусламжтай ийм их сайн төсөл юм байгаа юм. Сая Чинбүрэн сайд хэллээ. Анхны зураг нь 2017 онд 2022 онд шинэчилсэн. 2025 онд Европын Сэргээн босгол хөгжлийн банкнаас нөгөө санхүүжүүлэх гэж байгаа банкнаас нь баг нь хүрч ирээд сая энэ зураг төсөв ТЭЗҮ-үүдээ дахиж баталгаажуулсан байгаа юм. Ингээд өөрсдөө хяналт тавиад явах учраас энэ энийгээ дахиж үнийн хувьд өртгийн хувьд эрсдэлд орохгүй гэдгийг баталгаажуулаад та нар харин энийгээ нөгөө хурдхан ойрын хугацаанд эхлэх юм бол эрсдэлд орохгүй, удаагаад байх юм бол харин баталгаа гаргаж өгч чадахгүй шүү л гээд байгаа юм.

Г.Тэмүүлэн: Батбаяр гишүүн нэмж тодруулъя.

Д.Батбаяр: Тэгэхээр нөгөө зүрх судасны өвчтэй хамаатныгаа сахиад эмчлүүлэх гээд 3 дугаар эмнэлэг дээр олон хонож байсан түүхтэй л дээ. Их төвөгтэй байдаг хэцүү байдаг. Тэнд сахиур хийж байгаа олон хоногоор байж байгаа иргэдэд маань их хүндрэлтэй нөхцөл байгаад байдаг. Өөрөө өөрсдийнхөө боломжоо ашиглаад л тэнчээ эмчилгээнийхээ хажуугаар сахиуруудад нь боломж олгох гээд л яваад байдаг эмнэлгийн хамт олон. Тэгэхээр энэ хөрөнгө оруулалт энэ манай үр ашигтай, үр дүнтэй Монгол хүний амьдрал зөвхөн Монгол хүн гэхгүйгээр энэ бүс нутагтаа яг энэ их нөлөө үзүүлсэн ийм ажил болох байх гэж бодож байна. Тэгээд дэмжиж байгаа шүү.

Г.Тэмүүлэн: Баярлалаа Батбаяр гишүүн үг хэллээ. Заяабал гишүүн асуулт асууя.

Б.Заяабал: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе ээ.

Тэгэхээр 3 дугаар эмнэлгийн өнөөдрийн байгаа нөхцөл байдал үнэхээр хүнд л дээ. Ачаалал ч их. Тэгээд энэ шинэ эмнэлгийг дэмжихээс өшөө арга байхгүй. Орчин үеийн ийм технологийн ийм эмнэлгүүд Монгол Улсад зайлшгүй байх шаардлагатай байгаад байгаа юм аа. Монголчуудын тараасан материалаас аваад үзэхэд Монголчуудын энэ үндсэндээ нийт 75 хувь нь зүрх судасны өвчнөөр өвчлөх магадлал өндөртэй байна гэж байгаа. Нас баралтын хамгийн өндөр хувийг эзэлдэг гэж байгаа.

Дээрээс нь эмчилгээ үйлчилгээний ихэнх нь 3 дугаар эмнэлэг дээр хийгддэг гээд тэгж байгаа. Тэгэхээр энэ байдлыг ч гэсэн аваад үзэхэд бол энэ шинэ эмнэлэг бол зайлшгүй шаардлагатай байгаа гэдэг нь тодорхой байгаа. Энийг бол бүгдээрээ л дэмжиж байгаа. Тэгээд эндээс би нэг хэд хэдэн бодлогын асуултууд асуумаар байна аа. Өмнө нь асуугаад хариултаа авч чадаагүй ганц, хоёр зүйлүүд асуултууд байгаа. Энийгээ би асууя.

Нэгдүгээрт нь Монголчуудын үндсэндээ 75 хувь нь зүрх судасны өвчтэй байдаг юм бол яг юунаас шалтгаалж байгаа юм бэ? Монголчуудад энэ амьдралынх нь хэв маяг нь болохгүй байна уу? Хоол унд нь болохгүй байна уу? Энэнээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой танин мэдэхүйтэй холбоотой иргэд олон нийт рүү чиглэсэн ямар санал зөвлөмжүүдийг ЭМЯ гаргаж байгаа вэ? Өглөөнийхөө хоолонд юу идэх юм? Өдрийн хоолонд юу идэх юм? Оройны хоолонд юу идэх юм? Яаж зүрх судасны өвчнөөс бид нар хамгаалагдах юм? Ямар дасгал хөдөлгөөн хийх юм гэдэг юмаа 1 дүгээрт яримаар байна аа. Монголчууд бол 10 мянган хүнд ноогдох орны тоогоор дэлхийд 4 дүгээр байранд ордог. Эмнэлгийн орны ашиглалт 60 хувьтай гэсэн ийм Дэлхийн банкны судалгаа тооцоонууд байна лээ шүү дээ. Гэтэл бид нар эмнэлэг нэмж барина л гэдэг ийм зүйл яриад сууж байгаа. Өмнө нь Эдийн засгийн байнгын хороон дээр би хэлсэн үгээ фэйс бүүк дээр оруулж тавьсан. Энэтэй холбоотой иргэдээс миний доор коммент хэлбэрээр ч ирсэн хувийн чатаар ч ирсэн байгаа. Монголчууд энэ төрөлжсөн эмнэлгээр явдаг нь энэ буруу.

3 дугаар эмнэлэгтэй өрсөлдөх ямар ч эмнэлэг алга аа. Тэнд нэг даам гарчихсан хэдэн эмч нар байна, сайн эмч нар ч байна. Эмчилгээний чанар муу ч байна гээд янз янзын хүсэлтүүд ирж байгаа юм. Тэгээд эрүүл мэндийн ингээд цаашдаа ингээд төрөлжсөн эмнэлэг явуулаад бүх үзлэг үйлчилгээгээ ингээд 3 дугаар эмнэлэг рүүгээ аваад ингээд ачаалалтай яваад байх уу гэдэг дээр 2 дугаар асуулт.

Гуравдугаарт нь энэ эрүүл мэндийн санхүүжилтийг яаж зөв болгох вэ? Хэдэн жилийн өмнө энэ гүйцэтгэлээр буюу энэ нэг худалдан авагчийн загварт шилжсэн байсан. Тэр үед эмнэлгүүд харьцангуй гайгүй ашигтай ажиллах ийм боломж үүсэж байсан. Эрүүл мэндийн эмнэлгүүд чинь ашигтай ажиллаж байж. Өөрөөр хэлбэл энэ тоног төхөөрөмжийгөө дээврийнхээ засварыг төсвөөс мөнгө нэхэхгүйгээр өөрсдөө хийх шийдэх ийм боломж үүснэ шүү дээ. Энэ дээр Сангийн яам маань ямар бодлого барьж байгаа вэ?

Дөрөвдүгээрт нь энэ эрүүл мэндийн салбарыг либералчлахтай холбоотой ямар бодлогууд оруулж ирж байгаа вэ? Одоо ингээд улсаас зээл аваад ингээд эмнэлгүүд бариад байя л гэдэг ийм бодлого яваад байх юм уу? Хувийн сайн чанарын эмнэлгүүд оруулж ирэхгүй юм уу? Японы, Солонгосын өндөр эмнэлгүүд Монголд орж ирээд.

Г.Тэмүүлэн: Заяабал гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн сайд Чинбүрэн 5 номер. Асуултад хариулна.

Ж.Чинбүрэн: Заяабал гишүүний асуултад хариулъя аа. Ер нь өвчлөлийн гол шалтгаан бол бид буруу зуршилтай. Хамгийн түрүүнд та зөв хэллээ хоол унд. Мах өөх тосны хэрэглээ. Өнөөдөр бид нар стэп 4 судалгаагаар Монголчуудын дунд өөх тосны муу өөх тосны агууламж хэр байгааг үзэхэд л дандаа л холестерин болон муу

өөхний агууламж өндөр байгаа нь ерөөсөө л энэ зүрх судасны өвчлөлийн хамгийн эхний хэсэг.

Хоёр дахь нь бид одоо хөдөлгөөний хомсдолтой. Дээрээс нь архи тамхины хэрэглээ. Тэгэхлээр энэ муу зуршлаас сайн хэвшил рүү оръё гэдэг ийм том бодлого өнөөдөр бид одоо Нийгмийн эрүүл мэндийн тусламжийн хуультай болсноороо ЭМЯ-ны одоо бас нэг нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх муу зуршлаас сайн зуршил, хэвшил рүү шилжье гэдэг ийм том арга хэмжээг 2026 онд эхлүүлэх гэж байгаа. Энэ бол бид урьдчилан сэргийлэх хамгийн том ажил болно.

Хэдийгээр урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа эхэллээ ч түүний үр дүн нь 15-аас 20 жилийн дараа гардаг. Нөгөө хүн хэвшээд дасгал хийдэг болоод, илүүдэл жингүй болоод архи тамхи хэрэглэхгүй байна гээд яахад энэ нь өөрөө үр дүн нь 15-аас 20 жилийн дараа өгдөг.

Тийм учраас бид параллель эмчилгээний асуудлаар давхар явж байхгүй бол тун ноцтой. Тийм ээ. Тэгэхлээр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, дээрээс нь 3 дахь нь эмчилгээ гэдэг энэ тогтолцоог гурвууланг нь зэрэг нутагшуулж байж бид зөв амь аврах иргэдийнхээ амь насыг хамгаалах энэ боломж бүрдэнэ. Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог бид өнөөдөр төсөв хэлэлцэж байгаа учраас маш олон талаас нь ярьж байгаа. ЭМД-ын тогтолцоо ер нь бол хийсэн аргачлал нь явж байгаа зүйл нь тийм буруу биш ээ. Энэ бол жинхэнэ таны хэлдэг либералчлалыг дэмжиж байгаа бодлого явж байгаа юм.

Тухайлах юм бол улсын эмнэлэг, хувийн эмнэлэг гэж ялган санхүүжилт өгдөг байсан 20 оноос өмнөх тогтолцоог өнөөдөр улс ч эмчилсэн, хувийн эмнэлэг ч эмчилсэн санхүүжилтийг жигд өгнө. Харин ачааллыг бид жигд дааж байна уу гэдэг дээрээ анхаарах ёстой. Ачаалал, эрүүл мэндийн ачаалал гэж юу вэ гэхлээр хүнд өвчнүүдийг амьсгалын дутагдалд орчихсон, эрчимт эмчилгээнд байж байгаа, ухаангүй байгаа энэ их өртөг зардал ихтэй эмчилгээг хийдэг багтай эмнэлгүүдийг бид илүү санхүүжүүлэхгүй бол бизнес болгоод хөөчих юм бол энэ өөрөө зүгээр л үр дүнтэй сайхан мөнгө олдог салбарыг нь түүгээд авчих юм бол энэ том алдаа болно. Иймэрхүү алдаа цухалзаад эхэлсэн учраас бид ЭМД-ын санг зөв болгох хөтөлбөрийг төсөвтэй хамт өргөн барьсан байгаа. 8 зорилго 30 хийх ажлыг өргөн барьсан. Энүүгээрээ дамжуулаад нэгд бид ЭМД-ын тогтолцоогоо зөв болгоё алагчилдаггүй болгоё, мөнгө хулгайлдаггүй болгоё оо гэсэн ийм том зорилго тавиад ажиллаж байгаа шүү.

Дараагийн яг одоо ямар хоол идэх вэ, яах вэ гэдэг дээр би бас Мөнгөн-Өлзий эмчийг хариулт өгчхөөсэй гэж хүсэж байна.

Г.Тэмүүлэн: 4 номер ажлын хэсгээс нэмж тайлбар өгье.

Х.Мөнгөн-Өлзий: Та бүхэнд баярлалаа. Эрсдэлт хүчин зүйлийн хувьд 75 хувь гэдэг нь нөгөө нэг нийт хүн амын 75 хувь нь нэг буюу түүнээс дээш эрсдэлтэй байна гэдгээрээ явж байгаа. 30 хувь нь бол 4-өөс 5 эрсдэлтэй буюу өндөр эрсдэлтэй бүлэг гэдгээрээ явж байгаа. Тэгэхлээр бид хэдийн хувьд Зүрх судасны үндэсний төвийн хувьд эмнэл зүйн тусламж үйлчилгээ бол зөвхөн ажлын нэг хэсэг болдог. Ерөнхийдөө нийт ачааллынхаа хориод хувийг бол бид нар урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа руу чиглүүлж ажиллаж байгаа. Яг одоогийн хэрэгжиж байгаа Люксембургийн төслийн хувьд ч гэсэн бүтэн нэг компонент хэсэг нь бол урьдчилан

сэргийлэх үйл ажиллагаа руу чиглэдэг. Бидний хувьд бол энэ үйл ажиллагааны хүрээнд нөгөө кайф судалгаа, мэдлэг, хандлага, дадлыг судлах судалгааг хийсэн. Иргэдийн дунд.

Тэгээд үүн дээрээ үндэслээд үндэсний хэмжээнд зүрх судасны өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөсөн. 21 аймаг 9 дүүргийнхээ бүх эмнэлгийн ажилчдыг байгууллагуудыг энэ үйл ажиллагаандаа татаж оролцуулдаг. Тэгээд ер нь бол цаашдаа зөвхөн эмнэл зүйн тусламж үйлчилгээнээс гадна сургалтаа хийдэг, судалгаагаа хийдэг, гол нь урьдчилан сэргийлэх дээр тэргүүлж ажиллах ийм цогц төв байна гэж байгаа.

Г.Тэмүүлэн: Заяабал гишүүн нэмж тодруулж асууя. Заяабал гишүүний микрофон өгье.

Б.Заяабал: Тэгэхлээр энэ эрүүл мэндийн салбарын чинь энэ шатлалын эмнэлгүүд өнөөдөр өргүй эмнэлэг гэж бараг алга болчихсон байгаа шүү. Бодит байдал дээр сумын эмнэлэг ч тэр аймгийн эмнэлэг ч тэр улсын тэр 1 дүгээр зэрэглэлийн эмнэлгүүд нь ч тэр. Тэгэхлээр эрүүл мэндийн санхүүжилт чинь болохгүй байна л гэсэн үг. Тогтолцоо чинь болохгүй байна л гэсэн үг. Энэ дээрээ та нар бодлого арай нэг өөр бодлого явахгүй бол улсаас ингээд эмнэлэг бариад л яваад байдаг. Урсгал засвар, урсгал зардал нь цаашдаа өснө эмнэлгийн ажилчдын тоо цаашдаа өснө. Одоо даахгүй байгаа энэ урсгал зардал чинь цаашдаа нэмэгдээд явна. Энэ эрүүл мэндийнхээ системийг зөв эрүүл явуулахын тулд энэ дээр онцгой шинэчлэл зайлшгүй шаардлагатай байгаа шүү гэдгийг онцгойлж хэлье.

Хоёрдугаарт нь тэр төрөлжсөн эмнэлэгтэй холбоотой асуудал асуусан. Нэг эмнэлэг дагнаж зүрх судас гэхээсээ илүү өрсөлдөөн үүсгэх хэмжээгээр, хэлбэрээр энэ эмнэлгүүдийгээ жигд авч явахгүй бол нэг эмнэлэг ингээд эмнэлгийн салбар дотор чинь үйлчилгээ дотор чинь монопол үүсэх ийм асуудал болоод байна шүү гэдгийг.

Г.Тэмүүлэн: Заяабал гишүүний асуултад хариулъя. ЭМД-ын санхүүжилттэй холбоотой асуудал Сангийн сайд. 6 номер асуултад хариулъя.

Б.Жавхлан: Заяабал гишүүний асуултад би нэмэлт мэдээлэл өгье. Чинбүрэн сайд бараг хэлчихлээ дээ. Ер нь ЭМД-ын тогтолцоо маань 2021 оноос эхэлсэн байдаг юм. Ингээд 4 дэх жилийнхээ, үндсэндээ 5 дахь жилийнхээ төсөв рүү орж байна. Энэ тогтолцоо анх эхлэхэд ЭМД-ын сангийн нийт төсөв 1.2 их наяд байсан юм. Ингээд 4, тавхан жилийн дараа 2.2 их наяд буюу 2 дахин нэмэгдсэн. 2 дахин нэмэгдсэн байгаа. Гэтэл асуудал нь шийдэгдэхгүй байгаад байгаа. Тэгэхээр асуудал нь дотроо байгаад байгаа юм.

Тийм ч учраас бид 2026 онд өмнөх жилийн энэ жилийн тодотголын дараах дүнгээс нэмэгдүүлээгүй. Саяын Чинбүрэн сайдын хэлж байгаа бол Сангийн яам бид ярьж байгаад ЭМЯ. Хөтөлбөр буюу хойтон жил эдний салбарын хэллэгээр бол дотор үзлэг хийж байгаад цаашаагаа яах вэ гэдгээ шийднэ. Тэгэхгүй бол энэ ингээд юу ч идсэн ингээд доошоогоо шингэн алдаад байдаг хүн шиг болчихоод байгаа юм.

Г.Тэмүүлэн: Болсон уу Заяабал гишүүн. Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: Ямар ч байсан энэ Монгол Улсад нас баралтын шалтгааны 34.5-аас 35 хувийг эзэлж байгаа энэ шалтгаант нөхцөлийг бууруулах түүнд зориулсан энэ төрийн шийдэл хөрөнгө оруулалт зээл тусламж. Ямартай ч энэ нэг эмнэлэг бий болох гэж байгаад баяртай байгаа. Энийг бол 100 хувь дэмжинэ.

Нэгдүгээрт асуух асуулт нь болохлоороо энэ нас баралтын ойролцоогоор 35 хувийг эзлээд байгаа тэргүүлэх энэ шалтгаан нөхцөл энэ эмнэлэг баригдсанаараа симуляц буюу төсөөтэй аргын загварчлалын судалгаагаар ер нь хэчнээн хувь буурах вэ? Энэ асуулт яагаад асууж байна гэхлээр ер нь цаашдаа бид нар чинь нөгөө бүсчилсэн хөгжил гээд 6 орон нутгийн бүс байна төвийн бүс нь Улаанбаатар хоттой ойрхон гэж үзэх юм бол бусад 5 бүс байгаа.

Цаашлаад тодорхой хэмжээгээр бүсүүдийн нөгөө бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд чинь нийгмийн эрүүл мэнд болон энэ эмнэлгийн боловсролын энэ дэд бүтцүүдийг сайжруулах ийм агуулга байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр ер нь бол цаашлаад жишээлбэл баруун аймаг эс үгүй бол говийн бүс ч гэдэг юм уу яг ийм чиглэлийн 5 шатлалтай 5 дугаар шатлалын ч гэдэг юм уу ийм эмнэлгүүд барих юм уу. Энд ер нь цаашаагаа Чинбүрэн сайд яг энэ эрүүл мэндийн салбар дахь багтаамж агуулгаараа энэ эмнэлэг 4-өөс 5 жилийн дараа баригдаад ашиглалтад орсны дараагаар яг одоо тэр нас баралтын шалтгааны яг энэ энэ бүх эмнэлэгтэй хамааралтай зүйл нь хэчнээн хувиар буурах вэ. Энд яг тодорхой судалгаа байна уу гэж асууж байгаа юм.

Яагаад энийг асууж байгаа вэ гэхээрээ том багтаамжийг нь ойлгох гээд байгаа байхгүй юу?

Хоёрдугаарт та сая хэлж байна. Заяабал гишүүн асууж байна. Ер нь сая хавар 2 сарын 3, 4-нд утааны сонсголын үеэр мэдээж энэ Монголчуудын амьдралын хэв маяг идэж ууж байгаа зүйл, хэрэглэж байгаа тос, гаднаас орж ирж байгаа импортын бүтээгдэхүүн стандарттай холбоотой зөндөө зүйлүүд яригдсан. Гэхдээ хүний өөрийн амьдралын хэв маягийг хичээгээд, хичээгээд хортой утаатай орчинд амьдраад чармайгаад чармайгаад эрүүл мэндэд нь заналхийлж байгаа энэ орчин нөхцөлийн тухай бид судалгаа аягүй муу байлаа шүү дээ. Өөрөөр хэлбэл энэ утааны асуудал одоо ингээд эхэлж байна.

Тэгэнгүүт энэ хорт хавдрын шууд шалтгаан гээд та бас энэ хурлыг удирдаж байсан сонсголыг удирдаж байсан. Тухайн үед эрүүл мэндийн ТНБД Очирбат юу гэж хэлсэн гэхлээр ерөөсөө энэ Монголчуудын нийтлэг нас баралтын шалтгаан нөхцөлийг зүй тогтлоор нь судалдаг тийм лаборатори байх ёстой юм байна улс орнууд тийм юм байгуулчихлаа гэсэн. Тэгээд ийм лаборатори ч гэдэг юм уу нэг юм байгуулаад нэг ийм судалгаа шинжилгээнд суурилсан шийдвэр гаргалт, хөрөнгө оруулалтын дунд богино, богино дунд, урт хугацааны нэг ийм загварчлалаа хэдүүлээ ойлгохгүй болохлоор ерөнхийдөө бид нар эмнэлэг гээд л зарчмын хувьд дэмжинэ шүү дээ. Сая хэлж байна шүү дээ 126 гишүүн, 120 ортой ортой эмнэлэг гээд л тиймээ. Тэгээд асуудал бид нар урт хугацааны судалгаа суурилсан байдлаар хандахын тулд аливаа юмыг ингээд ерөнхий симпац сэтгэл хөдлөлөөр биш нухацтай шийдмээр байна. Энэ тал дээр та мэдээлэл өгөөч.

Гуравдугаарт 1 минут сунгаж болох уу,

Г.Тэмүүлэн: болохгүй юу? Нэмж асуух уу? Эрдэнэболд гишүүн нэг минут нэмж өгье.

С.Эрдэнэболд: 3 дугаарт тэр өнгөрсөн хавар эрүүл мэндийн удирдах ажилтны зөвлөгөөн дээр Ерөнхийлөгчийн ивээл доор болсон. Тэнд ямар мэдээлэл явсан бэ гэхлээрээ зөвхөн БНСУ руу жилд 200 орчим сая долларын гадагшаа валютын урсгал явж байна аа. Энэ бол яг иргэдийн халааснаас. Хашаа байшингаа зараад хамаг юмаа барьцаанд тавиад бүх юмаа дэнчин тавиад явж байгаа.

Тэгэхээр энэний яг хэчнээн процент нь жишээлбэл яг энэ зүрх судасны асуудал бөгөөд энэ эмнэлгийн асуудал дотооддоо шийдэгдлээ гэж бодоход энэ валютын гадагшаа явж байгаа урсгал хэчнээн хувиар шийдээд эх оронд үлдэх юм. Тэгээд хэчнээн иргэд ядуурлаас аврагдах юм гэдэг ч юм уу. Яг иймэрхүү яг эдийн засаг, харилцан хамаарлын тооцоо, судалгаануудын талаар мэдээлэл өгөөч ээ.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүний асуусан асуултад хариулъя. Сангийн сайд Жавхлан 6 номер.

Б.Жавхлан: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя аа. Би тэр нөгөө төлбөрийн тэнцэлтийн хэсэг дээр нь холбоотой мэдээлэл өгье. Түрүүн Номин гишүүн бас ярьж байсан. Монголбанкны судалгаагаар төлбөрийн тэнцэл дээр манай гарах урсгал дээр эрүүл мэндийн аялал жуулчлал буюу гадагшилж байгаа урсгал дээрээ 163 сая долларын төлбөр төлдөг юм байна. 163 сая доллар шүү. Үүний 60 хувьтай тэнцэх эмчлүүлэгчтэй цуг явж байгаа хамаатан садан тэр баг нэмэлт зардал гаргадаг юм байна. 60 хувьтай тэнцэх. Тэгэхээр энэ чинь үндсэндээ бараг 220, 230 сая долларыг бид нар эрүүл мэндийн салбарт дандаа гадагшаа төлж байна гэсэн үг. Гадагшаа төлж байна гэсэн үг. Саяын таны хэлж байгаа тэр 30-аас 35 хувь гэдэг дээр бид нар ойролцоогоор харж болох байх.

Тэгэхээр энэ чинь нэг 70-аас 80 сая доллар. Одоо яг энэ сүрэг судасны чиглэлийн гадагшлах урсгал дээр явдаг юм байна аа. Тэгэхээр энийгээ бид үнэхээр дэлхийн хэмжээний олон улсын хэмжээний бүс нутгийн хэмжээний 5 дугаар зэрэглэлийн эмнэлгээ барьж чадах юм бол энийгээ нэг 95 нь нэг бүтэн аваад үлдчих болов уу л гэсэн зорилготой шүү дээ.

Тэгэхээр ийм хэмжээний бид нар урсгал авах нь. Дээрээс нь бүс нутгийн гэж байгаа бол ийм хэмжээний тодорхой хэмжээний ийм аялал жуулчлалын наашаагаа авах ийм урсгал гарч ирэх нь болов уу гэж ийм хүлээлт байдаг юм байна. Манай эрүүл мэндийн салбарынханд.

Г.Тэмүүлэн: Чинбүрэн сайд нэмж хариулт өгье. 5 номер.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр ерөөсөө бид энэ төсөөлөл их чухал байдаг. Тэгэхлээр энэ 5 дугаар зэрэглэлийн ахисан түвшний энэ эмнэлэг байгуулагдсанаараа энэ төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг байгуулагдсанаараа ерөөсөө хамгийн гол зорьж байгаа зүйл бол бид нас баралтыг 60-аас 65 хувь, тэр дотроо бүүр анхаарал татаж байгаа зүйл бол энэ чинь нөгөө 44-өөс 65 насны буюу ид хөдөлмөрлөх насны хүмүүс нас бараад тахир дутуу болоод байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ нөхцөлийг 25 хувь бууруулна, 25 хувь. Дээрээс нь бид бол ингэж харж байгаа шүү. Энэ ерөөсөө ганцхан нэг төв бариад л Монгол Улс зүрх судасны

асуудлаа бүгдийг нь шийдчихнэ гэж байгаа зүйл биш. Би түрүүн хэлсэн. Дараагийн та бүхэнд танилцуулах гэж байгаа төсөл маань ойрын 2-оос 3 жилд хэрэгжиж байгаа бүх аймгуудад харвалт шигдээсний эмчилдэг төвүүд барина. Бүх аймгуудад. Тэгэхдээ эмнэлэг барихдаа биш. Тоног төхөөрөмж хүний нөөц сургалтыг хийнэ. Байшин дутуу газар нь байшинг нь бариад явах юм.

Тэгэхээр энэ 2 хоорондоо бүгд ингээд холбоотой. Одоо баригдах гэж байгаа энэ төв маань сургалтын том бааз. Нөгөө эмч нараа сургадаг. Телемедицин энэ чинь хамгийн чухал зүйл шүү. Одоо хэрэгжээд байгаа. Цахим систем бий болчихсон. Энэ Люксембургийн 8 удаагийн төслөөр ямар өвчтөнийг тэр хол байгаа Дорнодоос ч юм уу, Увсаас ч юм уу, Ховдоос нааш нь шилжүүлэх үү, шилжүүлэхгүй юу, яаж шилжүүлэх юм. Шилжүүлж явж байхдаа ямар эмчилгээ хийх юм бэ гэдгийг нь хүртэл шийддэг ийм тогтолцоо тогтчихсон. Энийгээ илүү сайжруулах энэ нөхцөлийг хангаад ингээд явна аа. Ер нь гадагшаа явж байгаа урсгалыг зөвхөн ойрхон хийсэн судалгаагаар харахад 2018-аас 2019 онд 141 сая доллар гарсан.

Бусад гэр бүлийнх нь зардалд нь 91 сая доллар. 64.3 нь эмчилгээний бус зорилгоор зүгээр л гадагшаа мөнгө урсаад л яваад байгаа. Тэгээд энэ бүх мөнгө бол одоо Монголдоо л байх хэрэгтэй.

Г.Тэмүүлэн: Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Зүрх судасны үндэсний төвийн зээлийн хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байгаа юу? Эрдэнэбат гишүүнээр тасаллаа. Ганхуяг гишүүн үг хэлнэ.

Х.Ганхуяг: Энэ төслийг дэмжих нь зүйтэй байгаа юм. Тэгэхдээ яах вэ би энэ Чинбүрэн сайдад анхааруулаад хэлэхэд болж өгвөл энэ ЭМД-ын сангаа болж өгвөл санхүүгийн мэргэжлийн хүн тавьж цаашдаа явуулахыг анхааруулъя аа. Энэ чинь бол эмч хүн хийдэг тийм үйл ажиллагаа биш байхгүй юу. Уг нь гүйцэтгэлийн санхүүжилт чинь маш зөв тогтолцоо байхгүй юу. Тэгээд л сүүлдээ архины донтолтыг хүртэл ЭМД руу оруулаад л, архичин хүн нэг 7, 8 удаа яаралтай түргэн тусламжаар аваачиж дусал залгаад л. Ийм юм чинь түргэн тусламжийн мөнгө гарах ёсгүй шүү дээ. Ер нь тэгээд яг шаардлагатай хүмүүс нь өнөөдөр мөнгө байхгүй гээд үйлчилгээгээ авч чадахгүй, маск байхгүй, бээлий байхгүй, ариутгалын бодис байхгүй ингэж явж болохгүй л дээ. Одоо үндсэндээ 3, 4 удаа яг сүүлийн 3, 4 удаа яг ЭМД дээр дандаа эмч нар ажиллалаа. Дандаа л мөнгө нь байхгүй гээд л оны эцэс рүүгээ ингээд мөнгөгүй гээд сууж байдаг. Уг нь нэг менежмент хийвэл маш зөв тогтолцоо байхгүй юу. Тэгээд сая та аймаг болгон ингээд л зүрх судасны эмнэлэг байгуулна гээд. Наадах чинь буруу шүү дээ.

Ер нь тэгээд л дараа нь эмч нь олдохгүй. Тэгээд урсгал зардлаа дийлэхгүй. Яг ингээд л Заяабал гишүүний ярьж байгаа пойнтууд байна. Тэгээд болж өгвөл энэ нэгдсэн эмнэлгүүд дээрээ аймаг байна уу, хот байна уу нэгдсэн эмнэлгүүд дээр түшиглээд энэ зүрх судасны асуудлаа хавдрын асуудлуудаа шийддэг байх. Ингэж байж бас нэг хүмүүс чинь яг тэр өрсөлдөөний зарчим руугаа орж эхлэх байхгүй юу. Тэгээд гүйцэтгэлийн мөнгөө хэн сайн хийдэг нь авдаг, хаана сайн эмч байгаа нь авдаг. Болохгүй бол бид нар ингээд л мөнгө нь дутлаа гээд л ингээд л байнга хойноос нь мөнгийг нь нэмээд яваад байх боломжгүй байхгүй юу.

Тэгээд нэг ийм тал дээр анхаармаар байна. Тэгээд гишүүдийгээ яг энэ сайн зээлийн болон тусламжийн төслийг дэмжээд өгөөрэй гээд хүсье ээ.

Г.Тэмүүлэн: Ганхуяг даргад баярлалаа. Хосбаяр гишүүн үг хэлнэ.

Г.Хосбаяр: Эрүүл мэндийн салбарт хэрэгжих энэ төслийг дэмжиж байна. Тэгээд мэдээж одоо өртөг, хэрэгжих хугацаатай холбоотой шүүмж хэлбэл хэлмээр. Тэгэхдээ одоо тийм зүйл яриад яах вэ. Тэгэхдээ ер нь зүгээр Монголчууд бид нар бас нэг Монголчууд бид нар бие биеэ дэмжих дотоодын ААН-ээ дэмжих тал дээр онцгой анхаармаар юм шиг санагддаг юм. Тэгэхгүй бол магадгүй нэг Монгол залуучууд, Монгол компани хувийн хэвшилд ийм эмнэлэг барья гээд төсөл хийгээд явсан бол ямар нэгэн байдлаар улс төртэй хутгаад ч юм уу, амжилтгүй болох байсан байх л даа.

Тэгээд сүүлийн 10 гаран жил Монголчууд үнэхээр юмыг хийж бүтээж чаддаг болсон. Монголын хувийн хэвшил бол юм хийж бүтээж чаддаг болсон. Одоо манай энэ ордны хойно байгаа Чингисийн музейг гэхэд бид нар 50 гаран тэрбум төгрөгийн төсөвт өртөхөөр улсын төсвөөр 2 жил хүрэхгүй хугацаанд Монголчууд бариад өнөөдөр энийг бас л дэлхийн хэмжээний л музей гэж үзэх байх. Тийм учраас дэлхийн хэмжээний музейг 2 жилийн хугацаанд Монголчууд бид өөрсдөө барьчихсан. Энэн шиг ингээд Засгийн газрын баталгаа гаргаад ч юм уу ингээд төр засаг нь дэмжээд өгдөг бол энэ хувийн хэвслүүд ийм. Эрүүл мэндийн ч бай, аль ч салбарын ийм томоохон төслийг хэрэгжүүлээд аваад явах бүтээн босгох бүрэн чадвартай болсон гэж би үзэж байгаа юм.

Тийм учраас цаашдаа бид нар одоо гаднын хүн гэхээр бөхөлзөөд бүх ажлыг нь бүтээж өгөөд бүх юм нь яваад байдаг. Дотоодын ААН, Монголчууд болохоор бие биеийгээ дэмждэггүй. Хэн нэгэнтэй холбож харддаг, эсвэл авлига нэхдэг ч гэдэг юм уу ийм байдлаар битгий яваасай гэж ингэж бодож явдаг. Тэгээд цаашдаа одоо энэ Монголд хэрэгтэй энэ эрүүл мэндийн ч бай, аль ч салбарын томоохон төслийг Монголчууд өөрсдөө гар бие оролцож хийдэг, бүтээдэг, босгодог, цаашдаа аваад явдаг ийм байгаасай л гэж бодож байна.

Арван жилийн өмнө Монголын компаниудыг юу ч хийж чаддаггүй л гэдэг байсан. Одоо бол Монголчууд 50 давхар байшин ч барьж байна, Чингисийн музейгээ ч барьчихлаа, цахилгаан станцаа ч барьж түрүүчийнхийг нь ашиглалтад оруулаад чадаж байна.

Тийм учраас цаашдаа бид нар улсаараа, энэ Монголчууддаа дотоодын ААН-дээ бас итгэдэг баймаар байна аа. Тэд нарыгаа дэмждэг баймаар байна гэдэг ийм үгийг хэлэх гэсэн юм баярлалаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Очирбат гишүүн үг хэлнэ.

Г.Очирбат: Гишүүддээ оройн мэнд хүргэе. Энэ ЕСБХБ-ны энэ Зүрх судасны үндэсний төвийг байгуулах төсөл Эдийн засгийн байнгын хороогоор орж ирээд бид нар дэмжсэн юм. Нөгөөдөх нь болохоор АХБ-аас ерөнхий зээлийн хэлэлцээр орж ирээд хойшлуулсан байгаа. Тэгээд дэмжихдээ Сангийн яамныханд хэлж байсан. Тодорхой энэ санал, дүгнэлтийг би уншиж түрүүн танилцууллаа.

Энэ дээр юу гэсэн бэ гэхээр Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа тухай бүр зээлийн хүүгийн хэмжээг тогтоосон банкны шийдвэрийг зээлдэгч заавал биелүүлэхээр заасан талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга Сангийн яамны зээлийн тооцооллыг зөв тооцсон эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат өнөөдрийн байдлаар баталгаат овар найт санхүүжилтийн хувьсах хүү хэд байгаа талаар төсөл хэдий хугацаанд судлагдаад, хэзээ хэрэгжих талаар санхүүгийнх нь тооцооллыг нь Их Хурлын гишүүдэд мэдээллээр хангаарай гэсэн.

За гээд бүгдээрээ гараад явсан. Өнөөдөр энд бид нар Төсвийн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооны гишүүд сууж байхад яг одоо энэ хэдэн төгрөг гараад хэзээ төлөгдөөд эцсийн дүндээ хэдэн жилийн дараа энэ төсөв дээр ямар дарамт ирэх талаар бүгдэд нь нэг хавтгай бэлдээд мэдээлэл өгөөч гэсэн. Өгнө гэж гараад 2 хоног өнгөрлөө. Одоо хүртэл өгөөгүй. Хойшдоо энэ байдлаа Сангийн яамныхан анхаарах хэрэгтэй. Өгөөгүй шүү дээ. Одоо тэгээд хаана байгаа юм. Тэгвэл энд ширээн дээр та энэ гишүүдэд байгаа нь хаана байгаа юм, өгөөгүй шүү дээ, тарааж өгөөгүй байна. Өгнө гээд гарсан. Одоо хүртэл өгөөгүй 2 хонож байна.

Тэгэхээр цаашдаа Жавхлан сайдаа та зүгээр энэ асуулт хариултынхаа цаг дуусаад үг хэлж байна шүү дээ. Сонсчих л доо та. Ирсэн бол би ирсэн л гэнэ шүү дээ. Ерөөсөө худлаа ярьсан юм алга. Өгөөгүй тараагдаагүй байна. Хэдэн сарын хэдэнд аваад тухайн үеийнх нь зээл нь тийм байгаад тэдний хугацаа нь дуусаад тэр хугацаанд төсөв дээр ийм дарамт ирээд явна гэх ёстой. Тэгэхээр энэ мэдээллүүдээ Улсын Их Хурлын гишүүдэд бүрэн хангаж өгөөрэй гэж Сангийн яамныханд хэлье.

Би яагаад гэвэл Эдийн засгийн байнгын хороон дээр энэ асуудал дээр 3, 4 асуулт асуугаад хариултаа авсан. Тэгээд 3, 4 гишүүн яг энэ асуултыг асуугаад мэдээллээ тарааж өгөөрэй гэсэн гээд хавтгайг нь тараагаагүй. Худлаа гэвэл Үүрийнтуяа гишүүн Уянга гишүүн рүү залгаад асуу. Тэр хүмүүс аваагүй байгаа. Тэгээд хойшдоо энэ мэдээллүүдээ нээлттэй болгож өгөөрэй Сангийн яамныхан, Жавхлан сайд аа. Тэгэхгүй тэгээд цаагуураа та нар юу хийж байгааг бид нар мэдэхгүй байгаа шүү. Үгүй харин тийм би танд хэлж байна шүү дээ. Үгээ хэлж байна, үгээ хэлж байна. Мэдээллээ л ил тод нээлттэй болгоод өгчхөөрэй.

Г.Тэмүүлэн: Даваагийн Цогтбаатар гишүүн үг хэлье.

Да.Цогтбаатар: Энэ төслийг бол дэмжиж байгаа. Тэгээд Чинбүрэн сайдад хандаж ер нь ЭМЯ-нд хандаж хэлэхэд бол энэ орон нутгийн эмч нар энэхүү эмнэлэг дээр ирээд. Дадлага сургуулилт хийгээд тодорхой хэмжээний тоног төхөөрөмжтэй харилцаад буцаад орон нутагтаа очоод яг энэ чиглэлийнхээ энэ үзлэг оношилгоог хийгээд орон нутагтаа бас нэг тодорхой хэмжээний илрүүлэг хийдэг, эмчилгээгээ хийдэг, тоног төхөөрөмжтэйгөө харьцдаг байх талаас нь энэхүү эмнэлэг дээрээ анхаарч өгөөрэй гэж хүсэж байгаа юм.

Г.Тэмүүлэн: Баясгалан гишүүн үг хэлье.

Ж.Баясгалан: Бүгдээрэнд нь энэ оройн мэнд хүргэе.

Тэгээд дан ялангуяа 3 дугаар эмнэлгийнхээ эмч удирдлагуудад юун түрүүнд баярлалаа гэж хэлье. 3 дугаар эмнэлгийн маань Люксембург улстай хийсэн энэ 20 жилийн уйгагүй ажлын үр дүнд өнөөдөр энэ зүрх судасны эмнэлэг маань баригдах

хэмжээндээ хүрлээ. Энэ төслийн санхүүжилтүүд шийдэгдэх хэмжээнд хүрч байна. Тэгээд энийг Улсын Их Хурал хүртэл ингэж босгож оруулж ирсэн энэ явдалд бол маш их талархаж байна аа.

Зүрх судасны өвчин бол угаасаа дэлхийд номер нэг байгаа үхлээрээ. Монгол Улс гэхэд л одоо 18200 иргэн зүрх судасны өвчнөөр хорвоогоос хальсан байгаа. Тэгээд ер нь энэ Зүрх судасны эмнэлэг дээр дан ялангуяа 3 дугаар эмнэлэг дээр иргэдийн тавьсан саналын дагуу бид очиж ажилласан. Тэгээд ажиллах явцдаа энэ Зүрх судасны төвийн төсөлтэй сайн танилцсан. Маш удаан хугацаанд. Тийм болохлоор энэ төслийг бол бүгдээрээ дэмжээрэй гэж та бүхнээсээ уриалах гэж байна. Яагаад гэвэл үнэхээр энэ бид нар 100 ортой эмнэлэг гээд л яриад байна. Энэ чинь хэвтэх орон 100 болохоос биш, тэр эмчилгээний хагалгааны тасаг тэгээд одоо манайд хамгийн нэн шаардлагатай байгаа зүрх судасны мэс заслын дараах сэргээн засах эмчилгээний тасагтай болох гээд байна шүү дээ бид нар. Энэ чинь өөрөө хүн тэр хагалгааны дараа хэвийн амьдралдаа эргэн орох тэр боломжийг бүрдүүлж өгөх юм.

Тийм болохлоор энийг нь олж хар.

Хоёрдугаарт гэвэл төслийн буцалтгүй санхүүжилт байна нөгөөдөх нь болохлоор зээл байна. Зээлийнх нь дүнгээр энэ барилгыг тооцоод үзэхлээр метр квадрат нь 8.2 сая төгрөг болж байна. Эмнэлгийн тусгай зориулалтын барилга гэхэд энэ маш боломжийн. Энэ үнэхээр боломжийн үнэ байхгүй юу. Бид нар олон эмнэлэг хавдрын эмнэлэг дээр тооцоо хийж үзсэн, шинэ хавдрын эмнэлэг дээр тооцоо хийж үзсэн. Тэгэхэд 8.2 сая гэдэг бол үнэхээр яг өнөөдрийн байдлаар бол эмнэлгийн тусгай хэрэгцээний барилгад маш боломжийн үнэ шүү. Тэгэхээр энэ ажлыг ямар нэгэн шалтгаанаар зогсоохгүйгээр хөрөнгө оруулалт дээрээ маш сайн хяналттайгаар тэгээд тендер бүх юм маш ил тод яваад өгөөсэй гэж хүсэж байна.

Тэгээд бүгдээрэнд нь амжилт хүсье. Ямар ч байсан бид нар Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилт 2030-д тусгагдсан байгаа.

10 мянган хүн хүн амд зүрх судасны өвчлөлийг 14 болгож багасгая гэсэн тэр зорилтдоо хүрэхийн тулд явж байгаа гэж ойлгож байгаа. Тийм болохлоор энэ эмнэлэг болоод энэ асуудлыг 100 хувь дэмжиж байгаа шүү. Тэгээд бас энийг эхнээс нь оруулж ирсэн 3 дугаар эмнэлгийнхэндээ тэгээд бас ЭМЯ, Сангийн яамныхандаа баярлалаа. Эмнэлэг барьж байгаа юм чинь бид нар баярлахаас аргагүй. Эмнэлгийг барих ёстой.

Г.Тэмүүлэн: Норовын Алтанхуяг гишүүн үг хэлнэ.

Н.Алтанхуяг: Би энэ 2 зээл хэлэлцэх юм байх гэсэн нэг юм хэлэлцэж байгаа юм байна. Би тэр эмнэлгээсээ илүү энэ Монгол Улсын гадаад өр зээл гэдэг дээр л санал хэлэх гэж ирсэн юм.

Хоёрдугаарт нь өр зээлийг аваад аль зэрэг үр ашигтай зарцуулж байгаа юм бэ гэж. Би Эрдэнэтээс сонгогдоод тэнд нэг хогийн үйлдвэр барина гэж нэг 10-аад сая доллар аваад юу ч босгохгүйгээр ингээд дуусаж байгааг хараад би зөндөө л олон удаа Их Хурал дээр ярьсан. Ер нь Монгол Улсын өр зээл ийм гэрлийн хурдаар өсөөд байж болдог юм байх даа. Би асуулт асуугаагүй шүү. 475 сая доллар аваад од. Одоо нэг хэдэн сургууль барина, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулна

ажиллах хүчний ур чадвар хөгжүүлнэ гамшгийг сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлнэ. Улсынхаа төсвийн хөрөнгө оруулалтыгаа үр ашигтай болгож болохгүй л юм байх даа. Уг нь тэндээс л маш их хэмжээний мөнгө суларч гарч ирнэ дээ. Одоо зүгээр энэ 2 юм орж ирээд харахад 500 сая доллар 500 гараад явчхаж байгаа юм л даа. Тэгээд манай улсын төсвийн хөрөнгө оруулалт нь үр ашиг их муутай байдаг.

Тийм учраас би энэнийг бол хойшлуулах ёстой гэж бодож байгаа. Энэ засаг төр мөр нэг учир начраа олоод та нар маань энэ Монгол Улсыг хорлосон, ялангуяа энэ гаднаас авч байгаа зээл авахыг би дэмждэг. Тэгэхдээ юунд авах вэ гэдгээ үр ашгаа сайн бодож авахгүй бол болохгүй боллоо.

Хоёр дахь нь болохоор энэ эрүүл мэндийн салбарын асуудал. Одоо Чинбүрэн гишүүн маань ингээд сайд болчихсон. Би өмнөх сайд нарт ч зөндөө хэлсэн. Өнөөдөр Монголд мөнгөний асуудал алга. Менежментийн асуудал байна эрүүл мэндийн салбар чинь. Та гарч ирээд тэрний нэг социализм, коммунизмын үеийн нэг урьдчилан сэргийлэх үзэл бүхий нэг компанит ажлыг энэ арай биш байна энийг оновчтой болгох ёстой гээд түр зогсоосон юм шиг харагдсан би зөв гэж бодож байгаа. Таны хийж байгаа эхэлж байгаа тэр нэг менежментийн чиглэлийн хэд хэдэн ажлыг би бол хувьдаа дэмжиж байгаа.

Энэ ЭМД-ыг ингээд идчихэж байгааг нь бол арай л хэтэрч байгаа. Тэгээд манайх хараа нэг ийм эзэнгүй айл боллоо, бодлогогүй айл боллоо, аавгүй айл боллоо, үгүй энэ нэг ийм сонин айл. Толгой молгой байхгүй. Тэгээд тэр сайд нар нь ч их солигдох юм. Тэгээд тэр доогуур нь эрх мэдэл нь оччихоод байна. Хуучин тэгсэн шүү дээ эрүүл мэндийн салбарын 1, 2, 3, 4. Боловсролын салбарын 1, 2, 3, 4 ADB-ээс аваад л явсан. Тэр цаанаас зээл өгөөд байгаа газрын буруу биш. Унхиагүй бид нарын л буруу. Ийм юмаа нэг бодож ярих үгүй юм уу? Жавхлан чи орж ирээд нэг их гоё гоё юм яриад л, гүрийгээд л, тэгээд 1 гишүүн үг хэлэхээр тэр гишүүн бүхэнд нэг их атмандаад л заагаад л солиороод суух юм. Чиний үед энэ Монгол Улсын гадаад өр зээл дампуурлаа шүү дээ. Чиний үед ер нь манай Монголын эдийн засаг, эдийн засагсаад байх юм байхгүй. Санхүү бол дампуурлаа шүү дээ. Яагаад энэ Ардын намын сайд нар ажлаа муу хийгээд энэ бүх юм нь дуусаад байхад одоо энэ станцыг нь хүртэл дэлбэрээд байхад сайд нар нь яагаад байгаад байдаг юм яадаг юм энэ. Өөр өөр үзүүлэлтээр нь байлгаад байдаг юм уу? Ард түмэнд хэрэгтэй юм юу хийв гэдгээрээ л байлга. Байлгах байлгахгүй тухай ярих юм бол танай хэдэн сайд нар бүгд байхгүй байх ёстой шүү дээ.

Ийм ийм юмаа ярьсан нь дээр байх даа. Би их санаа зовж их харамсаж байгаа. Би сүүлийн үед санал хэлээд ч нэмэргүй юм байна гээд харамсдаг л болсон. Та нар бол их сайхан гоё хүний амь аврах гэж байгаа юм чинь эмнэлэг бүхнийг босгох ёстой гэж ярьж байна. Уг нь зөв байх тэгэхдээ бас буруу байна.

Г.Тэмүүлэн: Эрдэнэбат гишүүн үг хэлье.

С.Эрдэнэбат: Мөрийн хөтөлбөрт дэвшүүлж байсан зүрх судасны төвийн эмнэлгийн ажил, ажил хэрэг болох гэж байгаад баяртай байна. Зээлийн хүүгийн хувьд софер дээр нэмэх нь 1.6 гээд олон улсын жишиг. Уул нь хүү ийм л байх ёстой юм л даа. Бид нар чинь софер дээр нэмэх нь 5 хувьтай зээлийг Оюу Толгой дээр аваад 10 хэдэн жил болоод явчихсан ийм алдаанууд байгаа. Байшин барилга барих мэдээж гадаад хэлэлцээр учраас нарийн шалгууртай байдаг. Бид нар олон алдаа байгаа юм байна лээ. АХБ-аас авсан зээлүүдийн хүрээ зам барина л гэдэг. Манай

хүмүүсийн бүтэхгүй хүмүүсийн гараар ороод үндсэндээ тэр ажил нь ч явдаггүй. Гадаад дотоод хүмүүсийн хувьд ч гэсэн эвгүй байдалд ордог. Энэ тал дээрээ тэр гүйцэтгэж барих энэ зүйл дээр нь маш хариуцлагатай байх ёстой олон улсын нэр хүнд, магадгүй энийг амжилттай хийвэл цааш цаашдаа олон ийм боломж гарч ирэх болов уу гэж бодож байна.

Хүнийхээ нөөцийн асуудал дээр их анхаараарай. Маш том сайхан байшингууд барьдаг нөгөө мундаг сайхан эмчүүд маань хэдэн 100 мянган доллароор гадаад дотоод бэлтгэгдсэн хүмүүсээ гадагшаа алдаа тавиад туучхав. 5 жилийн дараа энэ хүмүүс чинь ажиллах гэдэг. Тийм учраас энэ байшин барихтай зэрэгцээд хүнийх нь асуудлыг бэлдэх юман дээр би хамт явж байна гэж ойлгож байгаа. Тийм үү сайд аа? Тийм учраас манай мэргэжлийн олон мэс заслын эмч нартай л уулзах юм хөөрхий. Тэгээд их ч мэс засал хийсэн ялгаа байхгүй бага ч хийсэн ялгаа байхгүй цалин хөлсний хувьд нэг тиймэрхүү л байна гэдэг гомдол их тээгээд явж байгаа. Манай 3 дугаар эмнэлгийн ер нь манай нарийн мэргэжлийн эмч нар дэлхийн зах зээлд гараад явчихад бэлэн тосоод авахад бэлэн хэдэн 10 мянган доллароор цалинжуулаад аваад явчих бэлэн байгаа юм байна лээ. Сувилагч нараа бид нар чинь ерөнхийдөө бараг тавиад туугаад дуусах гэж байна уу яах гэж байна.

Тийм учраас энэ нарийн нэг хүнийг гараад явангуут нь цаана нь хэдэн 100 мянган доллароор бэлдсэн тэр сургалт дадлага туршлага гэдэг юмыг хаяад явчхаж байгаа дээр нь ерөөсөө үнэлэлт дүгнэлт өгдөггүй яваад ирсэн.

Тийм учраас энэ тал дээр эрүүл мэндийн салбар дээр тодорхой үнэлгээ хүний нөөцийн хүн капиталын урсгалын гарах алдагдлын зардлыг эдийн засгийнх нь тоо тооцоогоор нь тооцох ёстой юм байна лээ.

Хоёр, гуравхан сая төгрөгтэй нарийн мэргэжлийнхээ эмчийг нэгдүгээрт бол хувийн эмнэлэг рүү алдаж байна.

Хоёрдугаарт бол гадагшаа алдаж байна. Эс үгүй бол өөр салбар руу алдаж байна. Энэ тал дээр нь анхаар гэдгийг хэлмээр байна. Онцлоод нэг зүйлийг хэлэхэд төвийн эмнэлэг барихад бусад аймгийнхаа эмнэлгүүд рүү хүний нөөцөө бэлддэг дадлага туршлага болгодог энэ өөрөө их үржигдэх төв болох ёстой. Магадгүй мянган км-ийн цаанаас зүрхний шигдээс болчихсон хүнийг авчирч ирж эмчилнэ гэдэг бараг боломжгүй. Манай Эрдэнэт дээр аймгуудаас аваад үзэхээр Эрдэнэт дээр Засаг дарга нь нэг хөрөнгө гаргаад бүлэн хайлуулах эмчилгээ гээд жилдээ 400 гаран сая төгрөг гаргаад тэгээд үндсэндээ тэр хүнийг харвасан хүмүүсийг аврах ийм ажлыг хийж байгаа. Яг энэн шиг аймгууд нийслэл ч гэсэн мөн ялгаа байхгүй тодорхой хэмжээний төсвөөсөө энэ эрүүл мэндийнхээ энэ эрсдэлтэй цаг хугацаатай уралдаж байдаг ийм зүйлээ дэмжээд аваад явах дээр давхар бид нар даатгалынхаа бодлогыг хүнийхээ нөөцийн бодлогыг авч явах хэрэгтэй юм байна.

2029 он гэхэд энд мэргэжлийн эмч нар нь бэлэн, тоног төхөөрөмж нь бэлэн ийм зүйлүүдийг хийх ёстой болов уу гэж бодож байна. Энэ Монгол Японы эмнэлэг дээр нэг зүйлийг хэлэхэд яг бид нар ингээд Монгол Японы юугаар ингээд эмнэлэг бариулчихсан. Тэгсэн чинь энэ жил нөгөө жил болгон өгч байх ёстой зардлыг нь 4 дахин бууруулчихсан гэх юм Жавхлан сайд аа. Одоо бид нар чинь гадаадаар эмнэлэг бариулчихаад сүүлд нь өөрийнхөө хүлээсэн үүргийг дараа нь бариулаад хүлээгээд авчихсан юм чинь ямар ч хамаагүй байхгүй гэж хандаж болохгүй байх юм. Над руу энэ Монгол Японы эмнэлгийг хандаад байгаа. Та бас анхаараарай. Нөгөө

Боловсролын яамны харьяа байгаад байгаа учраас боловсролын хэлтсүүдэд гарч байна лээ. Тэгэхээр энийг нөгөө цаашдаа гаднын хөрөнгө оруулагч байгууллагууд маань юу гэж ойлгох вэ тэ? Тэгээд цаашдаа ч гэсэн бид нар томоохон үүрэг хүлээх байх.

Г.Тэмүүлэн: Үг хэллээ. Даваасүрэн гишүүн үг хэлье.

Ц.Даваасүрэн: Би зээлийн төслийг дэмжиж байна аа. Ер нь энэ Люксембургийн вант Улсын энэ тусламж чинь зүрх судасны чиглэл нэг нь эмэгтэйчүүдийн чиглэлээр олон жил хэрэгжсэн байх, хяналт ч их сайтай явдаг юм байна лээ. Тийм учраас энэ 3 дугаар эмнэлгийн зүрх судасны эмнэлгийг бэхжүүлэх чиглэлд би тодорхой үр дүнгээ өгсөн байх гэж ингэж бодож байна.

Зээлийн хувьд бол боломжийн. 40 хувь нь буцалтгүй тусламж байгаа тохиолдолд бид авах хэрэгтэй шүү дээ. Билгийн морины шүдийг үздэггүй гэдэг шиг энэ дээр нэг их олон юм яриад яах вэ. Тэгэхдээ бид ер нь эрүүл мэндийн салбар маань цаашдаа зээлээ яаж төлөх юм бэ гэдгийг их анхаарах ёстой юм аа. Энэ зээлийг ч гэсэн жишээлбэл яаж төлөх вэ гэж. Энэ чинь 18 жилийн хугацааны дараа тийм үү? Би бол одоо энэ тоног төхөөрөмжөө авахдаа ч гэсэн би их алсыг хараасай гэж бодож байгаа. Гар утас орж ирж байсан гар утас маань өнөөдөр ямар болчхов. Тэрэнтэй ижилхэн энэ хиймэл оюун ухаан ороод ирэхээр эрүүл мэндийн салбар ямар болох вэ гэдгийг бид нар бодох хэрэгтэй. Өнөөдөр ухаалаг цаг, ухаалаг жорлонгоор хүн өөрийгөө хянадаг болох гэж байна шүү дээ. Цаашдаа. магадгүй энэ хиймэл оюун ухаан чинь танд оношилгоог чинь өөрөө бичээд өөрөө юмыг чинь бичээд өгдөг болчих байх, эмч маань хаачих вэ гэх мэтийн.

Тийм учраас энэ 18 жилийн дараа зээлээ яаж төлөх вэ гэдгийг одоогоос бид бодох ёстой шүү дээ. Ер нь бол эрүүл мэндийн салбарт энэ хиймэл оюун ухаан асар том өөрчлөлтийг удахгүй авчирна, удахгүй авчирна. Тэгэхээр би зүгээр яах вэ энэ чиглэл рүүгээ та нар минь энэ зээлийн энэ юу энэ тэрээ эргэж төлөх чиглэл энэ тэр дээр бодолтой байгаарай. Энэ 6 саяын тоног төхөөрөмж авахдаа ер нь хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжийг авч эхэлж анхаарахгүй бол 2 жил ашиглаад нөгөөдөх нь хаягдчихдаг болох вий тэ. Энэ техник технологийн дэвшил, энэ хиймэл оюун ухааныхаа хөгжилтэй нэлээн уялдуулсан ийм сонголтнуудыг ажлын даалгаврыг нь гаргахдаа тавих, шаардлагаа тавихдаа ингэж бас анхаараарай гэдгийг хэлмээр байна. Тэгээд төслийн үр дүнгийн тал дээр энэ зөвлөх компаниуд авч ажиллаж байгаа байлгүй.

Тийм учраас бид нар бол энэ төсөл, энэ үр ашгийн тал дээр одоо олон зүйл ярих нь илүүц байх аа. Тэртээ тэргүй энэ ОУБ-ын төсөл тэгээд хөндлөнгийн хяналтаа тавигдаад явдаг учраас. Тэгээд төслийнхөө харин бидний зүгээс гаргах тэр шаардлагуудаа л техникийн шаардлагуудаа ажлын даалгавруудаа сайн тавиарай гэдгийг хэлье. Тэгээд эргэж төлөгдөх дээр анхаарна биз. 18 жилийн дараа төлөгдөх төсөл шүү дээ.

Тийм учраас энэ чиглэл дээрээ л анхаараад яваарай. Тэгээд энэ төслийг би дэмжиж байна аа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Нэг хүний дараа санал хураалт явагдана. 2 Байнгын хорооны ажлын албаныхан гишүүд рүү зар хүргээрэй групп дээр нь бичээрэй,

гишүүдийг дуудаарай. Санал хураалт явахад дөхөж байна шүү гишүүд орж ирээрэй. Батжаргал гишүүн үг хэлнэ.

Ж.Батжаргал: Гишүүд ажлын хэсгийнхний оройн амгаланг айлтгая аа. Бидэнд ярих юм олон байгаа байх. Гэхдээ энэ төсөл дээр бол яах аргагүй дэмжихээс өөр арга байхгүй ээ. Зүрх судасны өвчлөл Монголд нэлээн жин дарж байна. Тэгээд энүүнээсээ урьдчилан сэргийлэх гэдэг юм уу, чадамж бий болгох, ур чадвар бий болгох чиглэлээр нэлээдгүй олон жил ажиллаад нэлээн том боломжийг бий болгосон.

Дээр нь энэ чиглэлээр нь дахиад үргэлжлүүлээд, тодорхой хэмжээний томоохон төслийг хэрэгжүүлбэ түүнийхээ 40 хувийг нь буцалтгүй тусламжаар өгье өө гээд. Тэгээд бас бидний зээлжих зэрэглэл өнөөдөр нэлээн гайгүй байгаа. Энэ сүүлийн босгосон бонд эд нар чинь бол тэгээд хөвөгч хүү, нэмэх нь тэр тооцогдож байгаа хүү энэ тэрийг хараад байхаар зэрэг нэлээн бага байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр ийм цаг үедээ ийм гайгүй өртөгтэй зээлүүдийг татаж авч хэрэгцээтэй зүйлдээ бүрэн гүйцэд ашиглах ёстой.

Тийм учраас би бол энэ төслийг энэ зээлийн хэлэлцээрийг хэдүүлээ бүрэн дэмжих ёстой юм гэдгийг зориуд хэлмээр байна. Ер нь эрүүл мэндийн салбар дээр энэ шатлал хоорондын уялдааг хангах, тэр хүн ам байршиж байгаа шатлал дээрх эрүүл мэндийн салбарынхаа тогтвортой ажиллагааг хангах түүний чадамжийг нэмэгдүүлэх чиглэл рүү бид онцгой анхаарах ёстой юм шүү. Энэ бол бид нарын хамгийн том барих ёстой бодлого. Газар нутгийн хэмжээ ч тэр, байршил ч тэр, тархан суурьшил ч тэр. Ерөөсөө анхан шатын эрүүл мэндийн байгууллагаа ямар ч байсан хүн эндээ ч дэггүй болгох чадамжийг бий болгоод дараагийн шатлал руугаа шилжүүлж чаддаг. Шаардлагатай бол энэ асуудлаа шийдэх ёстой. Ингэхийн тулд тэнд бид чадамжийг ч бий болгох ёстой, санхүүжилтийн тогтолцоог нь ч энэнтэй нь зөв уях ёстой. Энэ тал руугаа нэлээн анхаарах хэрэгтэй. Энэ дэлхий нийтийн эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцоо энэ оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмжүүдийн хангалт нийлүүлэлтийн асуудлыг ч гэсэн судалмаар байгаа юм. Япон энэ тэрийн эмнэлэг чинь ер нь өөрийн гэсэн оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмж байдаг юм уу? Яг тэр үндсэн үйлдвэрлэгч нарын тоног төхөөрөмж суурилагддаг дараагийн технологи нь гарсан тохиолдолд тэр тоног төхөөрөмжийг байршуулаад л тэгээд л түрээсийн төлбөрөө төлөөд л явж байдаг юм байна лээ шүү дээ.

Тийм учраас энэ систем энэ тэрийг ер нь бид нар томоохон зэрэглэлийн шатлалын эмнэлгүүд энэ тэр дээрээ нутагшуулах юмаа хийхгүй бол болохгүй юм байна лээ. Нэг үнэтэй тоног төхөөрөмж аваад тодорхой хугацааны ар дээр үзүүлэлт юмнууд нь технологи нь хоцрогдоод явчихдаг. Тэгээд дараагийн худалдан авалтын тухай ярьдаг. Энэнээс бид гарах ёстой.

Тийм учраас зарим эмнэлгүүд дээр энийг туршиж үзээд нутагшуулах ёстой юм байна гэж ингэж ойлгож байгаа. Тийм учраас би Сангийн сайд, Эрүүл мэндийн сайд 2-ыг энэ чиглэл рүү ер нь мэргэжлийн багаа ажиллуулж энэ рүүгээ хэдүүлээ шилжих, эрүүл мэндийн хөгжлийн шинэчлэлийн нэг том бодлого байх ёстой биш биз дээ гэдэг юм байна. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Батжаргал гишүүнд баярлалаа.

Ингээд гишүүд зээлийн хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулж үг хэлж дууслаа. Гишүүд орж ирээрэй санал хураалтыг явуулъя.

Ажлын хэсгийнхний зүгээс 2 яамны зүгээс гишүүдийн хэлсэн саналуудыг анхаарч үзээрэй. 2 Байнгын хорооны 40 орчим гишүүд өнөөдрийн хамтарсан Байнгын хорооны хуралдаанд оролцлоо. Тодорхой саналуудыг хэллээ. Тэр дундаа сая эрүүл мэндийн салбартай холбоотой ЭМД-ын санхүүжилтийг өөрөө зөв болгох асуудлыг нэлээн хэдэн гишүүд одоо хөндөж ярьж байна. Энэ салбарын либералчлалын асуудлыг ярьж байна. Хүний нөөцийг сайжруулах асуудлыг хөндөж гар ярьж байна эрүүл мэндийн салбар энэ дээр анхаараарай. Хувийн хэвшлийнхээ оролцоог одоо дэмжих асуудлуудыг хөндөж ярьж байна.

Дээрээс нь мэдээж Төсвийн байнгын хорооны гишүүдийн гаргасан зээл тусламжийн үр ашигтай холбоотой төсөв санхүүгийн үр өгөөжтэй холбоотой асуудлуудыг хөндөж ярьж байна шүү. Тэгэхээр энэ дээр бол мэдээж аль аль 2 Байнгын хороо бол анхааралтай ажиллах, хариуцлагатай ажиллах шаардлагууд байгаа.

Санал хураалтыг явуулах бэлтгэлийг хангая. Батсүмбэрэл гишүүн орж ирж байна. Өөр орж ирж байгаа гишүүд байна уу? Мэдээж энэ төсөл өөрөө нийгэм эдийн засгийн онцгой ач холбогдолтой төсөл. Ингээд хүн амынхаа эрүүл мэнд болоод эрүүл мэндийн салбарт хийж байгаа маш том хөрөнгө оруулалт, маш том чухал төсөл гэж бол харж байгаа. Зээлийнхээ хэлэлцээр талаасаа ч гэсэн өндөр өгөөжтэй ийм төсөл байна аа. Тэгээд энийг бол манай 2 Байнгын хорооны бүх гишүүд бараг 100 хувь дэмжиж байна гэж бол ойлгож байгаа.

Гишүүд орж ирлээ. Үг хэлж дууссан санал хураалтыг явуулъя.

Санал хураалтын бэлтгэлийг хангая. Гишүүд хуруугаа хийцгээгээрэй төхөөрөмждөө. Санал хураалтын горимд бэлэн байгаа 19 гишүүн байна. Нийт энэчээ байгаа 24 гишүүн байгаа. Ороогүй гишүүн хэн байна. Ганхуяг гишүүн ороогүй байна уу орчихсон байна. Номин гишүүн орсон уу? Ганбаатар гишүүн, Номин гишүүн, Даваагийн Цогтбаатар гишүүн.

25 боллоо. Ингээд Монгол Улс ЕСБХБ хооронд байгуулах Зүрх судасны үндэсний төв байгуулах төслийн зээлийн хэлэлцээрийн төслийг зөвшөөрч гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай.

Санал хураалт.

Гишүүддээ баярлалаа. Нийт гишүүдийн олонх дэмжиж 67.6 хувиар дэмжигдлээ.

2 Байнгын хорооны хамтарсан хуралдааны санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлэхээр байгаад байгаа. Ингээд энэ зээлийн хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны хамтарсан хуралдаан ингээд дуусаж байна.

Ингээд залгуулаад Төсвийн байнгын хорооны гишүүд маань хуралтай байгаа. Төсвийн Байнгын хорооны гишүүд үлдээрэй. Төсвийн байнгын хорооны хуралдааны бэлтгэлийг хангая. Техникийнхэн анхаараарай. Хамтарсан Байнгын хорооны хуралдаан хаагдсан байгаа.

15.20 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА